



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА  
БОНЗ-ЫН ТАЙЛАН

2023



АГУУЛГА

ТУЗ-ИЙН ДАРГЫН  
МЭНДЧИЛГЭЭ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
МЭНДЧИЛГЭЭ

УДИРТГАЛ

|                                     |    |
|-------------------------------------|----|
| Ерөнхий агуулга                     | 11 |
| ХААН Банкны онцлох тоон үзүүлэлтүүд | 12 |
| БОНЗ-ын тоон үзүүлэлтүүд            | 16 |
| Бидний тухай                        | 18 |
| Тогтвортой хөгжлийн бодлого         | 24 |

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

|                                                   |    |
|---------------------------------------------------|----|
| ХААН Банкны компанийн засаглал                    | 27 |
| Тогтвортой хөгжлийн бүтэц                         | 29 |
| Тогтвортой хөгжлийн манлайлал                     | 30 |
| Ёс зүйн дүрэм                                     | 32 |
| Авлига хээл хахуулийн эсрэг                       | 34 |
| Кибер аюулгүй байдал ба мэдээллийн аюулгүй байдал | 35 |
| Дотоод аудит ба дотоод хяналт                     | 35 |

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

|                                                       |    |
|-------------------------------------------------------|----|
| Ногоон эх үүсвэр                                      | 42 |
| Ногоон бүтээгдэхүүн үйлчилгээ                         | 45 |
| Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага | 48 |
| Санхүүгийн хүртээмж                                   | 50 |
| Санхүүгийн боловсрол                                  | 54 |

## ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

|                        |    |
|------------------------|----|
| Тогтвортой ажлын байр  | 58 |
| Тогтвортой ажлын орчин | 66 |
| Харилцагчийн үйлчилгээ | 72 |

## ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨРӨНГӨ ОРУУУЛАЛТ

|                                  |    |
|----------------------------------|----|
| ХААН Банк сангийн тухай          | 78 |
| Боловсрол                        | 77 |
| Эрүүл мэнд                       | 80 |
| Байгаль орчин                    | 82 |
| Соёл урлаг                       | 84 |
| Орон нутгийн хөгжил              | 86 |
| Нийгмийн зорилтот бүлгийн дэмжих | 87 |

## ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТАЙЛАГНАЛ

|                             |    |
|-----------------------------|----|
| Дотоодын хамтын ажиллагаа   | 89 |
| Олон улсын хамтын ажиллагаа | 90 |
| Ил тод байдал ба тайлагнал  | 92 |

## ХАВСРАЛТ

|                                  |     |
|----------------------------------|-----|
| БОНЗ үйл ажиллагааны тайлан 2023 | 95  |
| Даян дэлхийн гэрээний 10 зарчим  | 103 |
| Тодорхойлолт                     | 104 |

## График

|                                                                           |    |                                                                                  |    |
|---------------------------------------------------------------------------|----|----------------------------------------------------------------------------------|----|
| График 1. Интернет болон мобайл банк хэрэглэгчдийн нийт тоо               | 13 | График 11. ХААН Банкны 2022 ба 2023 оны харилцагчдын сегментээр                  | 51 |
| График 2. Цахим банк хэрэглэгчдийн нийт тоо                               | 13 | График 12. ХААН Банкны 2023 оны харилцагчдын харьцаа байршлаар                   | 52 |
| График 3. Нийт гүйлгээний өдрийн дундаж                                   | 13 | График 13. ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт цахим банк хэрэглэгчдийн хүйсээр    | 53 |
| График 4. ХААН Банкны 2023 оны Ногоон зээлийн багц                        | 16 | График 14. ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт интернет банк хэрэглэгчдийн хүйсээр | 53 |
| График 5. ХААН Банкны 2023.12.31-ний байдлаарх хувьцаа эзэмшигчдийн бүтэц | 28 | График 15. ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт мобайл банк хэрэглэгчдийн хүйсээр   | 53 |
| График 6.ХААН Банкны дотоод хяналтын тогтолцоо                            | 39 | График 16. ХААН Банкны нийт ажилтны харьцаа байршлаар                            | 64 |
| График 7. ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт харилцагч                     | 50 | График 17. ХААН Банкны нийт ажилтны харьцаа албан тушаалаар                      | 64 |
| График 8. ХААН Банкны 2022 ба 2023 оны зээлийн багц хүйсээр               | 50 | График 18. ХААН Банкны нийт ажилтны харьцаа төрлөөр                              | 65 |
| График 9. ХААН Банкны 2022 ба 2023 оны хадгаламжийнн багц хүйсээр         | 50 | График 19. ХААН Банкны шинэ ажилтны хүйсийн харьцаа                              | 65 |
| График 10. ХААН Банкны 2022 ба 2023 оны харилцагчдын нас хүйсээр          | 51 |                                                                                  |    |

## Товчлол

- ТХ- Тогтвортой хөгжил
- БОНЗ- Байгаль орчин, нийгэм, засаглал
- МУ- Монгол Улс
- НҮБ- Нэгдсэн үндэстний байгууллага
- МХБ- Монголын хөрөнгийн бирж
- ЖДБ- Жижиг, дунд бизнес
- ТҮЗ- Төлөөлөн удирдах зөвлөл
- ХАБ- Худалдан авалтын бодлого
- ТХБ- Тогтвортой хөгжлийн бодлого
- UNICEF- Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
- PCAF- Partnership for carbon accounting
- HR- Human resource
- BIPV- Building-integrated photovoltaics
- BAPV- Building attached photovoltaics



## ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцгаана уу,

**ХААН Банкны ТУЗ-ийн нэрийн өмнөөс**  
Тогтвортой хөгжил, байгаль орчин,  
нийгэм, засаглалын тав дахь жилийн  
тайлангаа танилцуулж байгаадаа  
таатай байна.

Энэхүү тайландаа бидний тогтвортой  
ирээдүй рүү чиглэсэн аялал, үйл ажиллагаа,  
зээлийн туршлага, засаглал, нийгэмд үзүүлэх  
нөлөөллөөр дамжуулан оруулсан хувь  
нэмрийг тоймлоод байгаа билээ.



2023 оны 3-р сард ХААН Банк дэлхийн хөрөнгийн зах зээлд анхны 60 сая ам.долларын ногоон бонд гаргасан. Өнгөрсөн 12-р сард Монголын дотоодын хөрөнгийн бирж дээр ногоон бонд гаргаж, 17 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилт босгоод байна. 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар ХААН Банкны ногоон зээлийн багц 377 тэрбум төгрөгт хүрч, банкны салбарын нийт ногоон зээлийн багцын 47.1 хувийг эзэлж байна. ХААН Банк сан сүүлийн 16 жилд 12 тэрбум гаруй төгрөгийн 510 төслийг санхүүжүүлжээ.

ХААН Банк нь харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүртээ хамгийн шилдэг, хамгийн шинэлэг санхүүгийн үйлчилгээг хүргэх эрхэм зорилгыг биелүүлэхийн зэрэгцээ, бизнесийн стратегидаа тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсээр байна. Тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тогтвортой байдлыг бий болгох, нийгэмдээ эерэг нөлөө үзүүлж, хувьцаа эзэмшигчид түншүүддээ үнэ цэнийг хүргэхэд ур чадвар, хүсэл тэмүүлээ зориулж буй 5000 ажилтандаа ТУЗ-ийн нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

Бидний 2023 онд хэрэгжүүлсэн ажлын ахиц дэвшил, алхмын талаар илүү дэлгэрэнгүй танилцана уу хэмээн та бүхнийг урьж байна. Хөгжин дэвжсэн, тогтвортой дэлхий ертөнцийг цогцлооход хамтдаа гар бие оролцож, хамтдаа хөгжсөн ирээдүй өмнө зурайн хүлээж байна.

Хүндэтгэсэн,



**ДАРЬБУМ Түдэв**

(ТУЗ-ийн дарга)

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**Та бүхний энэ өдрийн амрыг эрэн мэндчилье!**

**Эрхэм хөрөнгө оруулагч, харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, хамтрагч түншүүд та бүхэнд ХААН Банкны 2023 оны Тогтвортой хөгжил ба Байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг хүргэж буйдаа баяртай байна.**

ХААН Банк “Тогтвортой хөгжилд манлайлагч” байх үнэт зүйлийнхээ хүрээнд бодитой олон ажлыг хийж гүйцэтгэсэн, ололт амжилт арвинтай жилийг үдлээ. Тухайлбал, 2023 онд бид “Тогтвортой бизнесийн дунд хугацааны стратеги”-ийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан, 2020 оноос мөрдөж буй Тогтвортой хөгжлийн бодлогодоо нэмэлт, өөрчлөлт оруулан уур амьсгалын өөрчлөлт, хүйсийн тэгш байдлыг хангах асуудлуудыг нэмж тусгалаа. Мөн банкны гүйцэтгэх удирдлагын түвшинд Тогтвортой хөгжлийн хороог шинээр байгуулан тогтвортой байдлын удирдлагын цогц, нэгдсэн засаглалыг бүрдүүлж, банкны зүгээс Тогтвортой хөгжлийн зорилгуудад үзүүлэх эерэг үр дүнг улам бэхжүүлэн ажиллалаа.



“ХААН Банк” ХК нь үндсэн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд Тогтвортой санхүүжилтэд анхаарч, санхүүгийн хөшүүргээр дамжуулан эдийн засгийг ногооруулахад голлох үүрэгтэй ажилладаг. Түүнчлэн Монгол Улсын “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийн 2-рт эрэмбэлэгддэг томоохон байгууллагын хувьд Тогтвортой хөгжлийн бодлогоор дамжуулан бүх талын оролцоог хангахыг зорьдог. Тодруулбал, банкны Тогтвортой хөгжлийн бодлого нь Тогтвортой санхүүжилт ба уур амьсгалын өөрчлөлт, Тогтвортой үйл ажиллагаа, Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал гэсэн 4 чиглэлийг цогцоор нь агуулсан байдаг. Та бүхэн энэхүү тайлангаас чиглэл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах болно.

2023 оны жилийн эцсийн байдлаар манай банкны ногоон зээлийн багц 377.4 тэрбум төгрөгт хүрснээр нийт арилжааны банкуудын ногоон зээлийн багцын 47.1%-ийг дангаар бүрдүүлж байна. 2022 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын Тогтвортой санхүүгийн замын зургийг баталсан байна. Замын зурагт тусгаснаар 2030 он гэхэд банк санхүүгийн салбарын нийт зээлийн багцын 10 хувийг ногоон зээлээр бүрдүүлэхээр зорьсон. Энэ хүрээнд ХААН Банк 2025 он гэхэд өөрийн нийт зээлийн багцынхаа 10 хувийг ногоон болгохоор зорьж буй. Мөн Монгол Улсын эдийн засгийг “ногооруулах” зорилгын хүрээнд олон улсын хөрөнгө оруулагчдаас урт хугацааны санхүүжилтийг жил бүр татан төвлөрүүлж, тайлант хугацаанд анхны ногоон бондыг дотоодын болон гадаадын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа.

Банк өөрийн үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах хүрээнд Улаанбаатар хот дахь Сөүл оффистоо нарны эрчим хүчний систем суурилуулж, тус оффисын эрчим хүчний хэрэглээний 20 хувийг цэвэр сэргээгдэх эрчим хүчээр хангадаг болсон. Үүгээр зогсохгүй орон нутгийн 5 тооцооны төвийн барилгыг нарны эрчим хүчээр 100 хувь хангаж эхэлсэн, цаашид ч энэ тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтод оруулж буй манай банкны бодит хувь нэмэр төдийгүй Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн 8 зарчмын нэг болох үлгэрлэн манлайлах зарчмын шилдэг жишээ болоод буй билээ. Мөн түүнчлэн ХААН Банкны ажилтан

бүрийн тэгш эрх, сүрч хөгжих боломж, эрүүл аюулгүй орчныг хангаж, тогтвортой ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны дарамт шахалтаас сэргийлж, зайнаас болон уян цагаар ажиллах боломжийг бүрдүүлэн, дундын оффисын концептийг нэвтрүүлэхэд бодлогын түвшинд анхаарч, олон улсын сайн жишигт нийцэж, тогтвортой хөгжлийн байгаль орчин хийгээд нийгэм, засаглалын санал санаачилгуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХААН Банкны хувьд компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк сангаараа дамжуулан 2007 оноос өнөөдрийг хүртэл нийт 510 гаруй төсөл, хөтөлбөрийг 12.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн нь нийгэмд бодитой хувь нэмэр оруулсаар байгаа билээ.

2023 онд бидний Тогтвортой хөгжлийн чиглэлд хийсэн санал санаачилга, ажлуудыг үнэлж, Монголын Тогтвортой санхүүжилтийн холбооноос “Шилдэг ToC байгууллага”-аар 3 дахь жилдээ шалгаруулсны зэрэгцээ 2024 оны турш манлайлан ажиллах ToC-ын “Манлай банк”-аар өргөмжлөөд байна. Мөн олон улсын MORS группээс олгодог “The Asia Corporate Excellence & Sustainability Awards 2023”-аас ХААН Банкныг “Азийн хамгийн нөлөө бүхий компаниуд”-ын нэгээр тодруулсан бол Монгол дахь Америкийн худалдааны танхимаас “Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлөөр манлайлагч байгууллага”-аар өргөмжилсөнд бид баяртай байна.

Ингээд Тогтвортой хөгжилд манлайлагч ХААН Банкны хамтын өсөлтийг бий болгох санал санаачилгууд, 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,



МӨНХТҮЯА Рэнцэнбат

(Гүйцэтгэх захирал)



## УДИРТГАЛ



## ЕРӨНХИЙ АГУУЛГА

Тогтвортой хөгжлийн зорилгуудад анхаарч, улс орныхоо эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулан ажиллах нь ХААН Банкны эртнээс хэрэгжүүлж ирсэн санаачилга билээ.

Энэ чиглэлд хийж буй ажлаа олон нийтэд ил тод тайлагнах зорилгоор бид 2018 оноос Тогтвортой хөгжлийн тайланг жил бүр бэлтгэн оролцогч талуудад нээлттэй хүргэж эхэлсэн.

Уг тайланд ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлогын үндсэн дөрвөн хэсэг болох Тогтвортой санхүүжилт болон уур амьсгалын өөрчлөлт, Тогтвортой үйл ажиллагаа, Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагналын хүрээнд хийсэн ажлуудын тухай мэдээлэл багтдаг.

ХААН Банк тогтвортой хөгжлийн чиглэлээр дотоодын болон олон улсын холбоод, санаачилга, нэгдлүүдэд элсэн хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэх тухай амлалт өгсний хувиар Монголбанк, Монголын тогтвортой санхүүгийн хөгжлийн холбоо НҮТББ, НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд, хамтран ажилладаг олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн банкуудад Тогтвортой хөгжлийн бодлогын үйл ажиллагаагаа тогтмол тайлагнаж, ил тод, нээлттэй хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн чиглэлд ХААН Банкнаас хэрэгжүүлж буй ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй та бүхэн энэхүү тайлангаас уншиж танилцахаас гадна тайлантай холбоотой санал хүсэлтээ [sustainability@khanbank.com](mailto:sustainability@khanbank.com) цахим шуудангаар илгээх боломжтой.

## ХААН БАНКНЫ ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

### Ерөнхий тоон үзүүлэлт

(2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)



Харилцагч

2,789,841



АТМ

1,297



Байгууллагын  
харилцагч

64,077



Киоск

444



Пос машин

43,626



Салбар

545



Картаар үйлчлэгч  
байгууллага

34,280



Ажилтан

4,689



Digi Go

Диги Го


4



## Дижитал банкны тоон үзүүлэлтүүд


(2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)

### Интернэт болон мобайл банк хэрэглэгчдийн нийт тоо



■ Интернэт банк хэрэглэгчдийн нийт тоо  
■ Мобайл банк хэрэглэгчдийн нийт тоо

### Цахим банк хэрэглэгчдийн нийт тоо



\*Цахим банк: ХААН Банкны нийт цахим суваг

\*Интернэт банк: ХААН Банкны аппликэшн, вэб


\*Мобайл банк: \*1917# залган ашигладаг Мобайл банк 2.0 үйлчилгээ

| Нийт гүйлгээний өдрийн дундаж | 2020      | 2021      | 2022      | 2023      |
|-------------------------------|-----------|-----------|-----------|-----------|
| Интернэт банк                 | 31,131    | 40,337    | 50,784    | 62,047    |
| Ухаалаг банк                  | 501,636   | 732,102   | 1,357,228 | 1,789,138 |
| Мобайл банк                   | 316,036   | 358,250   | 382,334   | 354,914   |
| Цахим банк (нийт)             | 1,096,923 | 1,337,746 | 2,023,116 | 2,242,959 |


Санхүүгийн тоон үзүүлэлт

|                      |                                                      | 2021   | 2022   | 2023   |
|----------------------|------------------------------------------------------|--------|--------|--------|
| АШИГТ АЖИЛЛАГАА      | Өөрийн хөрөнгийн өгөөж                               | 22.2%  | 32.0%  | 31.7%  |
|                      | Активын өгөөж                                        | 2.2%   | 3.4%   | 3.5%   |
|                      | Цэвэр хүүний маржин                                  | 4.8%   | 6.7%   | 6.9%   |
|                      | Зардлын харьцаа                                      | 44.4%  | 38.1%  | 40.2%  |
| ЗЭЭЛИЙН ЧАНАР        | Чанаргүй зээлийн харьцаа                             | 5.1%   | 5.3%   | 5.3%   |
|                      | Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа        | 120.0% | 135.1% | 127.9% |
| МОНГОЛБАНКНЫ ШАЛГУУР | Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)             | 15.6%  | 16.7%  | 18.6%  |
|                      | 1-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (9%+4%)        | 15.6%  | 16.7%  | 18.6%  |
|                      | Хөрвөх чадварын харьцаа (>25%)                       | 46.9%  | 46.0%  | 46.5%  |
|                      | Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-15%) | -1.9%  | 2.8%   | -6.3%  |
|                      | Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-30%) | -2.2%  | 3.0%   | -6.5%  |
|                      | Хамгийн том зээлдэгчийн харьцаа (<20%)               | 8.0%   | 7.8%   | 8.2%   |
|                      | Хамгийн том холбоотой этгээдийн харьцаа (<5%)        | 0.7%   | 3.3%   | 3.9%   |


### Нийт актив (тэрбум төгрөг)




### Нийт зээл (тэрбум төгрөг)







### Татан төвлөрүүлсэн хөрөнгө (тэрбум төгрөг)



### Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



### Зах зээл эзлэлт



Хаан Банк    Бусад банк


Дэлгэрэнгүй мэдээллийг ХААН Банкны  
Жилийн тайлангаас үзнэ үү.

## БОНЗ-ЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

(2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)

### Тогтвортой санхүүжилт ба уур амьсгалын өөрчлөлт

- Монгол Улсын ногоон таксономи ангилал
- Банкны эрсдэлийн удирдлагад уур амьсгалын эрсдэлтэй хамааралтай хүлээж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянан ажиллаж байна.



### Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

- ХААН Банк сан 2007 онд байгуулагдсанаасаа хойш 510 гаруй төсөл, хөтөлбөрийг 12.7 тэрбум гаруй төгрөгөөр санхүүжүүлэн нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулсаар байна.
- Нийт 14 мянган ширхэг мод тарьж, 2.3тн сая CO<sub>2</sub> бууруулсан байна.
- Эрүүл мэндийн аяны хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд нийт 170 мянга гаруй иргэнийг үнэ төлбөргүй хамруулав.



**14,000**  
мод тарьж



**2.3тн**  
CO<sub>2</sub> бууруулсан байна.



### Тогтвортой үйл ажиллагаа

- Улаанбаатар хотын Хүүхдийн 100 дахь ХААН Банкны Сөүл нарны эрчим хүчний BIPV болон BAPV системүүдийг хослуулан суурилуулснаар жилд **43.6тн CO<sub>2</sub>** бууруулж, **3,000ш** мод тарьж, 16.7тн нүүрс шатаахаас сэргийлж байна.
- Орон нутгийн 5 тооцооны төвийн барилгад BAPV систем бүхий нарны панелийг суурилуулснаар 1 жилд **6.85тн CO<sub>2</sub>** бууруулж, **1,223ш** мод тарьж, 6.85тн нүүрс шатаахаас сэргийлж байна.
- 2023 онд Тогтвортой үйл ажиллагааны хүрээнд 5ш цахилгаан автомашин банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах болсноор **5.6тн CO<sub>2</sub>** бууруулж мөн санхүүгийн хувьд энгийн машинтай харьцуулахад 6 дахин бага зардалтай байна.

### Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал

- 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар олон улсын банк, санхүүгийн байгууллагаас татсан урт хугацаат, тогтвортой санхүүжилтийн хэмжээ 568 сая ам.долларт хүрлээ.
- Олон улсын 14 орны, 29 банканд 14 төрлийн валютаар 51 гадаад ностро данс нээн, харилцаа, хамтын ажиллагааг амжилттай хадгалан ажиллаж байна.
- 2023 онд ХААН Банк нийт 200 гаруй тайланг хамтран ажиллаж буй олон улсын банк санхүүгийн байгууллагууд, олон улсын зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоогч байгууллагуудад хүргэж ажиллалаа.

## БИДНИЙ ТУХАЙ


### ХААН Банкны тухай

1991 оноос хойш санхүүгийн цогц үйлчилгээг тасралтгүй харилцагчдадаа хүргэсээр 33 жилийг ардаа үдээд буй ХААН Банк нь орон даяар нийт 545 салбар нэгжтэй үндэсний хэмжээний тэргүүлэгч арилжааны банк юм. Монгол Улсын нийт хүн амын 82 хувьд буюу 2.9 сая харилцагчид санхүүгийн үйлчилгээг тасралтгүй хүргэж ажиллаж байна.

ХААН Банк нь нийгмийн хариуцлагын санал санаачилга, төсөл хөтөлбөрүүдийг 2007 оноос хойш тасралтгүй, тууштай хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2011 оноос бизнесийн зээлүүддээ байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх болсон. Эрсдэлийг нь бууруулах шаардлага тавих замаар хариуцлагатай бизнесийг санхүүжүүлж, ингэснээрээ ногоон эдийн засгийг дэмжиж, Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулж байна.

Монгол Улсын Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн дагуу “ХААН Банк” ХК нь 2023 оны 4-р сард Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр олон нийтэд хувьцаагаа санал болгож, улмаар 6-р сард нээлттэй хувьцаат компани болсноор Монголын хөрөнгийн бирж дээр KHAN симболтой хувьцаа арилжаалагдаж байна. Тогтвортой санхүүжилтийн хүрээнд ХААН Банк 2023 оны 3-р сард олон улсын зах зээл дээр Монгол Улсаас анх удаа Ногоон бондыг амжилттай гаргасан бол 12-р сард Монголын хөрөнгийн бирж дээр анхны дотоодын ногоон бондыг гаргаад байна.

Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэхээр 2018 оноос эхлэн байгаль орчин, нийгэм, засаглалд эергээр нөлөөлөх ажлуудыг бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд шат дараатайгаар хэрэгжүүлж ирсэн. Ялангуяа уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл болон шилжилтийн санхүүжилтийн асуудлуудад онцгой анхаарал хандуулан энэ чиглэлийн ажлуудыг түлхүү хэрэгжүүлж байна. Мөн түүнчлэн ХААН Банк сангаараа дамжуулан компанийн нийгмийн хариуцлагын тэргүүлэх чиглэлүүдэд хувь нэмрээ оруулсаар байна.





1991 оноос хойш санхүүгийн цогц үйлчилгээг тасралтгүй харилцагчдадаа хүргэсээр 33 жилийг ардаа үдээд буй ХААН Банк нь орон даяар нийт 545 салбар нэгжтэй үндэсний хэмжээний тэргүүлэгч арилжааны банк юм. Монгол Улсын нийт хүн амын 82 хувьд буюу 2.9 сая харилцагчид санхүүгийн үйлчилгээг тасралтгүй хүргэн ажиллаж байна.

## Тогтвортой хөгжлийн түүхэн замнал



ХААН Банк нь нийгмийн хариуцлагыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс ажилтнууддаа чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бизнесийн орчинд хариуцлагатай ажиллах ёс зүйг бий болгоход анхаарч ажиллаж ирсэн.

2000-аад оны үеэс



НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэж, хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, авлига, хээл хахуулийн эсрэг үндсэн 4 бүлэгт 10 зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

2010 он



- НҮБ-аас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулахын зэрэгцээ Банкны бүх түвшний үйл ажиллагаатай уялдуулан нийцүүлэхээр зорьж эхэлсэн.

- “Нэг бүс – Нэг зам” санаачилгын хүрээнд боловсруулан гаргасан Ногоон хөрөнгө оруулалтын зарчимд нэгдэж, үндсэн 7 зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн.

2018 он



ХААН Банкны компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк санг үүсгэн байгуулж, нийгмийн сайн сайхны төлөө төсөл хөтөлбөрийг системтэй хэрэгжүүлж эхэлсэн.

2007 он



- Байгаль орчин, нийгмийн бодлогыг батлан хэрэгжүүлж, эзэлийн хүсэлтүүдэд Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж эхэлсэн.

2011 он

- Монголын тогтвортой санхүүжилт(ToC)-ийн хөтөлбөрт нэгдэж, дотоодын ToC-ийн ажлын хэсгийг байгуулсан.



ХААН Банк дотооддоо дагаж мөрдөх анхны Тогтвортой хөгжлийн бодлогоо батлан хэрэгжүүлж эхэлсэн.

2020 он



- Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-тай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, банкны бүх түвшний үйл ажиллагаанд хүүхдийн эрхийг дээдэлж, хамгаалж ажиллахаар боллоо.
- Зээлийн хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих “Partnership for Carbon Accounting Financials (PCAF)” санаачилгад нэгдэн орлоо.
- ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлогыг шинэчлэн баталж, уур амьсгал, хүний эрх, хүүхдийн эрх, тэгш байдал, биологийн олон янз байдал зэрэг асуудлыг багтаан орууллаа.

2023 он

2019 он



- Тогтвортой хөгжлийн тайланг анх удаа бэлтгэн өөрсдийн санаачилгаар олон нийтэд ил тод мэдээлж эхэлсэн.
- ТоС-ийн ажлын хэсгийг өргөжүүлэн Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг байгуулсан.



2022 он

- ХААН Банк брэнд шинэчлэлийнхээ хүрээнд байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, уриа үгээ шинэчилсэн бөгөөд “Тогтвортой хөгжилд манлайлагч байна” хэмээн үнэт зүйлсдээ тусгасан.
- Банкны Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийг үндсэн болон дөрвөн дэд ажлын хэсэг болгон өргөжүүлэн бүрдүүлэв.
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Тогтвортой хөгжлийн газрыг шинээр байгуулсан.
- Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээг Moody's агентлагтай хамтран хэрэгжүүллээ.

Тогтвортой хөгжлийн шагнал ба үнэлгээ



ХААН Банк нь 2023 онд тогтвортой хөгжил болон компанийн нийгмийн хариуцлагын чиглэлд дараах ололт амжилттай ажиллав.



"Asia Money" сэтгүүлээс **"Цахим шийдлээр тэргүүлэгч шилдэг банк", "БОНЗ-ыг хэрэгжүүлэгч шилдэг банк", "ЖДБ-ийг дэмжигч шилдэг банк"**-аар тус тус шалгаруулсан юм.



Монгол дахь Америкийн худалдааны танхимаас **"Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлөөр манлайлагч байгууллага"**-аар анх удаа тодруулан өргөмжиллөө.



ХААН Банк "Grand Bull Awards 2023"-ын **"Шилдэг засаглалтай компани"**-аар тодорлоо.



Монголын хүний хөгжлийн консорциумаас Хүний нөөцийн ажилтны өдрийг угтан зохион байгуулсан "HR awards 2023"-ын үеэр ХААН Банкийг **"Сургалт, хөгжлийн шилдэг стратегитэй байгууллага"**-аар тодруулан өргөмжиллөө.



MORS группээс зохион байгуулдаг "The Asia Corporate Excellence & Sustainability Awards 2023"-аас ХААН Банкийг **"Азийн хамгийн нөлөө бүхий компаниуд"**-ын нэгээр тодрууллаа.



Sustainable Fitch гэх байгаль орчин, нийгэм болон засаглал (БОНЗ)-ын үнэлгээ гаргадаг байгууллагаар үнэлүүлэн **"САЙН"** гэсэн үнэлгээ аваад байна.



Монголын Тогтвортой санхүүжилтийн холбооноос  
**"Шилдэг Тос байгууллага"**-аар 3 дахь жилдээ шалгаруулан  
 2024 оны **"Манлай банк"**-аар өргөмжлөв.



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлого нь дараах 4 үндсэн хэсгээс бүрдэнэ.



Тогтвортой хөгжлийн бодлого нь дараах суурь зарчмуудад тулгуурлана. Үүнд:



2000 онд НҮБ-аас зарлан тунхагласан **"Даян дэлхийн гэрээний дөрвөн бүлэгт 10 зарчим"**



2010 онд НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, Хүүхдийг ивээх сангаас хамтран тодорхойлсон **"Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд"**



2013 онд Монголын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрөөс тодорхойлсон 8 зарчим



2015 онд НҮБ-аас тодорхойлсон **"Тогтвортой хөгжлийн 17 зорилго"**



2015 онд 196 орны саналаар батлагдсан **Парисын хэлэлцээр**



2018 онд **"Бүс ба зам"** санаачилгын хүрээнд тодорхойлогдсон Ногоон хөрөнгө оруулалтын 7 зарчим



2020 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан **"Гэр бүлд ээлтэй бодлого"**

Дээр дурдсаны дагуу ХААН Банк 2019 оноос эхлэн үйл ажиллагааны жилийн тайлангаас гадна банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг нэмэлтээр бэлтгэн олон нийтэд нээлттэй тайлагнадаг болсон. Тогтвортой хөгжлийн тайланг банкны цахим хуудасны "Тогтвортой хөгжил" хэсгээс үзэх боломжтой.

### Тогтвортой хөгжлийн зарчмууд

ХААН Банк Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Байгаль орчин, нийгэм, засаглалын дараах зарчмуудыг бүх түвшний үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, оролцоог ханган ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧМУУД

### БАЙГАЛЬ ОРЧИН


- Ногоон санхүүжилт
- Ногоон орчин
- Уур амьсгалын өөрчлөлт
- Нөөцийн зохистой хэрэглээ

### НИЙГЭМ

- Хөдөлмөрийн эрх
- Хүний эрх
- Хүүхдийн эрх
- Санхүүгийн хүртээмж
- Ажилтны сэтгэл ханамж

### ЗАСАГЛАЛ

- Бизнесийн ёс зүй
- Инноваци ба цахим шилжилт



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



## ХААН БАНКНЫ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал нь компанийн зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг чиглүүлэх, хянах цогц тогтолцоо юм. Компанийн засаглалын бүтэц, түүний үйл ажиллагаа тогтвортой, сайн байх нь шийдвэр гаргалт, удирдлагын залгамж халааг оновчтой төлөвлөх, цаашид компани бие даасан, хараат бус байж, ирээдүйн хөгжилд тууштай анхаарах нөхцөлийг бүрдүүлж, олон эерэг үр дүн бий болгох давуу талтай.

Банкны компанийн засаглалын 4 үндсэн зарчим:

### 1 ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Банк хууль ёсныхоо эрх ашгийн хүрээнд өөрт олгогдсон хэрэгжүүлж буй эрх мэдэл болон үүргээ бүрэн хариуцах

### 2 ИЛ ТОД БАЙДАЛ

Олон нийтэд өгөх аливаа мэдээллийг тухай бүрд нь үнэн зөвөөр ил тод тайлагнаж хуваалцах

### 3 ТАЙЛАГНАЛ

Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад үйлдэл бүрээ тайлагнан итгэлцлийг бүрдүүлэх


### 4 ШУДАРГА БАЙДАЛ

Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад шударга, тэгш, ялгаваргүй хандах нөхцөлийг бүрдүүлэх

ХААН Банкны Компанийн засаглалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг "Жилийн тайлан 2023"-14-16-р хуудаснаас үзнэ үү.

## Хувьцаа эзэмшигчид

2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар “ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшлийн бүтэц дараах байдалтай байна.



ХААН Банкны 2023.12.31 байдлаарх хувьцаа эзэмшигчдийн бүтэц

## Төлөөлөн удирдах зөвлөл

ХААН Банкны ТУЗ нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, үүнд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан холбогдох дүрэм, журам, заавар, ХААН Банкны дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн компанийн зохистой засаглалыг

хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг. ТУЗ-ийн хурал нь сар бүр тогтмол хуралддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулдаг болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Жилийн тайлангийн 19-24-р хуудас болон Гүйцэтгэх удирдлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Жилийн тайлангийн 24, 25-р хуудаснаас үзнэ үү.

Хувьцаа эзэмшигчдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Жилийн тайлангийн 17, 18 дугаар хуудаснаас үзнэ үү.


# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БҮТЭЦ

## Тогтвортой хөгжлийн засаглал

ХААН Банкны Тогтвортой хөгжлийн засаглал нь ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо, Гүйцэтгэх удирдлагын түвшний Тогтвортой хөгжлийн хороо, Тогтвортой хөгжлийн газар болон Тогтвортой хөгжлийн тухайлсан чиглэлүүдийн ажлын хэсгүүдээс бүрдэж байна.

2024 оноос эхлэн Гүйцэтгэх удирдлагын түвшинд Тогтвортой хөгжлийн хороог байгуулан “Тогтвортой хөгжилд манлайлагч байх” үнэт зүйлсээ бодит үйл хэрэг болгохоор Тогтвортой хөгжлийн бодлогын зорилго, амлалт, зарчмуудын хэрэгжилтийг дэмжих, засаглалын хүрээнд ажлын хэсгүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавих, оролцогч талуудад банкны Тогтвортой хөгжлийн тайланг үнэн зөв, ил тод хүргэх зорилготойгоор ажиллаж эхлээд байна.

Үүнээс гадна банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороонд хагас жил тутам мэдээлдэг бөгөөд ингэснээр ТУЗ-ийн түвшинд энэ чиглэлийн мэдээ мэдээллээр хангах, оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН МАНЛАЙЛАЛ



**Тогтвортой санхүүжилт ба уур амьсгалын өөрчлөлт:** Олон улсын зах зээлд болон Монголын хөрөнгийн бирж дээр арилжсан Монгол Улсын анхны ногоон бонд нь салбартаа төдийгүй улсдаа манлайлал үзүүлсэн амжилттай ажил болоод байна. Эдгээр бондын эх үүсвэрээр 7 чиглэлд ногоон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээс гадна эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжин санхүүжилт үзүүлсээр байна.

**Тогтвортой үйл ажиллагаа:** Банк олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт татахад олон улсын БОНЗ-ын стандартуудыг үйл ажиллагаандаа хангаж ажиллах шаардлага үүсдэг. Үүнийг нэвтрүүлж, хангаж чадсанаар эх орондоо олон төрлийн зориулалт бүхий эх үүсвэр татаж, тухайн санхүүжилтийг үр дүнтэй ашиглах, олон улсын сайн туршлагыг судлах, шинэлэг технологиудыг бизнесийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ажилтнуудынхаа ур чадварыг дээшлүүлэх, харилцагчдад мэдлэг мэдээлэл олгох зорилгоор төрөл бүрийн техникийн туслалцаа авч банкны үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна. Мөн түүнчлэн олж авсан туршлага, мэдлэгээ банкныхаа оролцогч талуудтай нээлттэй хуваалцан үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, хамтын өсөлтийг бий болгоход төвлөрч байна.

**Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт:** ХААН Банк сангаараа дамжуулан нийгмийн сайн сайханд бодитой хувь нэмэр оруулах олон ажлыг тууштай зохион байгуулж ирсэн нь салбартаа төдийгүй Монгол Улсын хэмжээнд компанийн нийгмийн хариуцлагыг бодитоор хэрэгжүүлэгч сайн жишээ болсон. Үндэсний хэмжээний уламжлалт олон төслийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, системтэй мэдээ мэдээллээр ханган ажилласнаар бодитой үр дүн үзүүлдэг нь манлайлал болж буйн тод илрэл юм. Тухайлбал, 2011 оноос хэрэгжүүлсэн “Хавдрын эсрэг үндэсний аян”, 2017 оноос эхэлсэн “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян” зэрэг нь Монгол Улсын эрүүл мэндийн салбар, монгол хүний нас баралтын тэргүүлэх шалтгаануудын тохиолдлын хувь хэмжээг бууруулсан бодит үр дүнгүүдээс дурдаж болно.

**Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал:** Хамтын ажиллагааны хүрээгээ тэлж, Тогтвортой хөгжлийн зорилгуудыг дэмжин ажилладаг байгууллагуудтай идэвхтэй хамтарч байна. Тогтвортой хөгжил ба байгаль орчин, нийгэм эдийн засгийн чиглэлийн хүрээнд зохицуулагч байгууллага болон гадны санхүүжүүлэгч байгууллагын шаардлага стандартыг ханган 200 гаруй тайланг хүргүүлээд байна.

## ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### ХААН Банкны ёс зүйн дүрэм

ХААН Банкны ёс зүйн дүрмийг анх 2009 онд боловсруулан батлуулсан бөгөөд түүнээс хойш шинэчилж өөрчлөн өнөөг хүртэл банкны нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн дарга, гишүүд, үндсэн болон гэрээт ажилтнууд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд ажил үүргээ хэрэгжүүлэхдээ дагаж мөрдөж байна. Энэхүү Ёс зүйн дүрмийн зорилго нь дээр дурдсан ажилтнууд банкны зорилго, зорилтыг хэрэгжүүлж ажиллахдаа баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, зарчмыг тогтооход оршино.

Ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг ХААН Банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүдийн баримтлах, Удирдах ажилтны баримтлах болон Ажилтны баримтлах гэж тухайлсан байдлаар нарийвчлан тодорхойлсон байдаг бөгөөд ХААН Банкны ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ дараах нийтлэг зарчмыг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Хууль тогтоомжийг дээдлэх зарчим
- Үүрэгт ажлаа зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх зарчим
- Банкны өмч хөрөнгө, эд зүйлсийг ариг гамтай ашиглах зарчим
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим
- Авилга, хээл хахуулиас ангид байх зарчим
- Зах зээлийн мэдээлэл шударгаар олж авах зарчим
- Нууцыг хадгалах зарчим
- Харилцагчийг хүндэтгэх зарчим
- Үнэн зөв мэдээллээр хангах зарчим
- Удирдах, удирдуулах зарчим
- Өрсөлдөгч байгууллагатай харилцах зарчим

- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчим
- Зөрчил, дутагдлыг мэдэгдэх зарчим
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглах зарчим

### Бодлого, журмын шинэчлэлт

ХААН Банкны Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахын тулд бид дараах 2 чиглэлд шаардлагатай бодлого журмуудыг боловсруулан дагаж мөрдөж байна. Үүнд:

1. Мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг сахих чиглэл: 2023 онд ХААН Банкны Ёс зүйн дүрмийн хүрээнд тухайлсан ажил мэргэжил, үйл ажиллагааны чиглэлийн дагуу дараах журмуудыг шинэчлэн боловсрууллаа. Үүнд:
  - ХААН Банкны зээлийн ажилтны ёс зүйн журам: Энэхүү журмын зорилго нь ХААН Банкны зээлийн үйл ажиллагаанд оролцогч нийт ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг тогтооход оршино.
  - Удирдах ажилтны ёс зүйн журам: Энэхүү журмын зорилго нь ХААН Банкны бүх түвшний удирдах ажилтны удирдах чиг үүргээ чанартай, хариуцлагатай гүйцэтгэхэд удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлох, удирдах ажилтны тусгайлсан үүргийг тогтоох, мэргэжлийн зарчимч байдлыг хангах, удирдлага дахь ажилтнуудад ёс зүйн талаарх байгууллагын үзэл баримтлалыг төлөвшүүлэх болон түүнтэй холбоотой хэм хэмжээг тогтооход оршино.

- Төв банкны газар, нэгжүүдийн дотоод үйл ажиллагааны журмын өөрчлөлт: Төв Банкны газар нэгж бүр “Дотоод үйл ажиллагааны журам”-даа “Дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ” гэсэн шинэ бүлгийг нэмж тухайн газар нэгжийн үйл ажиллагааны чиглэл, мэргэжлийн онцлогт уялдсан ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж тусгасан.
2. Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах чиглэлд баримтлах ёс зүйн хэм хэмжээ: Ажилтан бүр ажил үүргээ гүйцэтгэхдээ хүний эрхийн мэдрэмжтэй байх, мөн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах чиглэлд хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллахтай холбоотой дараах бодлого журмыг дагаж мөрдөн байна. Үүнд
- “ХААН Банкны Хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого”-ыг 2022 онд боловсруулан баталсан. Энэхүү бодлогод хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд эрх тэгш, олон талт ялгаатай байдлыг хангах, хүн бүрийг хүндлэх, оролцоог дэмжих, аливаа төрлийн ялгаварлал, хавчин гадуурхалт, бусдын нэр хүндийг санаатайгаар унагах буюу гүтгэн гүжирдэх (үүгээр хязгаарлагдахгүй) зэрэг тэвчишгүй хэлбэрээс ангид орчин бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах замаар урт хугацааны тогтвортой ажлын байрыг бий болгох зорилтын хүрээнд ХААН Банкны баримтлах зарчмуудыг тодорхойлсон. ХААН Банкны нийт ажилтнууд мөрдөхөөс гадна ХААН Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлдэг гэрээт ажилтнууд, гэрээт байгууллагын ажилтнууд, мөн банктай ажил хэргийн харилцаанд орж буй бүх шатны оролцогч талууд ашиглах боломжтой
  - “ХААН Банкны ажилтны мэдээллийг хамгаалах журам”-ыг 2022 онд Монгол улс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн нийцлийг хангах, мөн ажилтнуудынхаа хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж, зохих хязгаар, хууль эрх зүйн хүрээнд харьцаж, ажилтны мэдээллийн хүрээнд хийгддэг үйл ажиллагааны ил тод байдлыг чанд сахин ажиллах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан.
  - “ХААН Банкны ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэр журам”-ыг 2022 онд баталсан. Журмын зорилго нь ажлын байрны аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчсэн хүний эрхийг дээдэлсэн орчин бүрдүүлэх, ажилтан бүрийг хүчирхийлэл, дарамтыг үл тэвчих хандлага, ёс зүйг эрхэмлэн ажиллах, хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлд баримтлах үйлдэх, эс үйлдэхүйг нарийвчлан тогтооход оршино.



## АВЛИГА ХЭЭЛ ХАХУУЛИЙН ЭСРЭГ

Гадны хамтран ажиллагч байгууллагуудын шаардлагыг хангах, банкныг санхүүгийн гэмт хэрэг, залилан, хууль бус үйлдэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, залиланг мэдээлэх, таслан зогсоох арга хэмжээний үйл явцуудад баримтлах зарчим, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, ёс зүйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор Санхүүгийн гэмт хэрэг, залилангийн удирдлагын бодлогыг шинээр боловсруулан ТУЗ-өөр батлуулсан бөгөөд уг бодлогын хүрээнд залилангийн эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнтэй хяналтын тогтолцоог бий болгох, шударга, ёс зүйтэй байх соёлыг төлөвшүүлэх, хадгалах зорилготой “Залилангийн эрсдэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр зорьж байна.



Мөн ХААН Банкны “Авлига хээл хахуулийн эсрэг баримтлах бодлого”-ын ерөнхий танилцуулгыг ХААН Банкны цахим хуудсанд нээлттэй байршуулсан бөгөөд хамтран ажиллах гэрээ байгуулсан нийт 39 аж ахуйн нэгжид авлига хээл хахуулиас ангид байх талаарх ёс зүйн сургалт, мэдээллээр хангах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлээ.

ХААН Банк нь шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн дээдэлж, банкны бүхий л үйл ажиллагаанд авлига, хээл хахуулийг огт хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд нийт ажилтан, эрх бүхий албан тушаалтнууд нь авлига, хээл хахуулийн асуудалд аливаа байдлаар холбогдохыг хориглосон байдаг. ХААН Банкны Ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтны хөдөлмөрийн гэрээнд авлига, хээл хахуулийн эсрэг баримтлах бодлого, хүлээх үүрэг хариуцлагыг тусгасан бөгөөд зөрчлөөс үүдэн гарах үр дагаврыг нийт ажилтнуудад тодорхой, тайлбарлаж өгсөн байдаг. 2023 онд банкны Удирдах ажилтны ёс зүйн журам болон Банкны ажилтнуудын ёс зүйн журмыг тус тус батлан гаргаж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн ХААН Банкны ажилтнууд авлига, хээл хахуультай холбоотой сэжигтэй үйлдэл илэрсэн тохиолдолд энэ талаар банкны шүгэл үлээх тусгай сувгийг ашиглан мэдээлэх үүрэгтэй байдаг.

Мөнгө угаах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгож, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилго бүхий Комплаенсийн дотоод хяналтын 2023-2025 оны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд авлига хээл хахуультай тэмцэх, холбогдох гүйлгээнд хяналт тавих, цаашид авч хэрэгжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлсон нь энэхүү хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн юм.

# КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

## Цахим аюулгүй байдал ба мэдээллийн аюулгүй байдал

### Мэдээллийн аюулгүй байдал

ХААН Банк нь харилцагчийн болон банкны мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд олон улсын шалгарсан арга барил, туршлага, санал санаачилга болон олон улсын ISO27001:2022, PCI DSS v.3.2.1, Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах стандартуудыг хэрэгжүүлэн тогтмол сайжруулан ажилладаг. Ингэхдээ боловсон хүчин, техник технологийн үйл ажиллагаа нь шилдэг туршлага болон арга барилыг хэрэгжүүлэх боломжтой байхад онцгой анхаарал хандуулдаг. Мөн түүнчлэн бид мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар банканд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг билээ.

### Олон улсын стандартууд

#### ISO 27001:2022 – Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандарт

ISO 27001:2022 стандартын хэрэгжилтийг хянах зорилгоор жил бүр Цахим аюулгүй байдлын газраас дотоод хяналт, шалгалтыг хийхээс гадна олон улсын аудитын байгууллагаар жил бүр баталгаажуулалт хийлгэж, үр дүнг холбогдох удирдлага, хороодод тайлагнаж тогтмол сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

### PCI DSS – Төлбөрийн картын аюулгүй байдлын стандарт

ХААН Банк нь Монгол Улсад төлбөрийн картын аюулгүй байдлын PCI DSS стандартын 3.2.1 буюу хамгийн сүүлийн хувилбарын бүх шаардлагыг хангасан банк боллоо. Энэхүү стандарт нь нарийн чанд шалгууртай бөгөөд хэрэгжилтийг жил бүр олон улсын эрх бүхий аудитын байгууллагаар шалгуулж, баталгаажуулдаг. Мөн “PCI DSS v3.2.1” стандартын шаардлагуудыг амжилттай хэрэгжүүлэн 2023 оны 12-р сард сертификатаа баталгаажуулсан билээ. Энэ сертификатыг авснаар Төлбөрийн картын олон улсын VISA байгууллагаас албан ёсны үйлчилгээ үзүүлэгч цахим лого ашиглах эрх бүхий байгууллага болсон.

### GDPR

Европын холбооны зөвлөлөөс боловсруулсан GDPR (General Data Protection Regulation) зэрэг Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах олон улсын стандартын шаардлагын 11 бүлэг хяналтуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Банкны хэмжээнд хувь хүний мэдээлэл хамгаалах зохицуулалтын дагуу зөрүүгийн шинжилгээг хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар 2023 оны 3-р сард хийлгэсэн бөгөөд тухайн байгууллагаас холбогдох ажилтнуудад 6 цагийн сургалтыг зохион байгуулж, сертификат олгосон. Ингэснээр ажилтнууд тухайн зохицуулалтын талаар мэдлэгтэй болж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, ойлгомжгүй байдлыг арилгахад дэмжлэг болсон.

## ISO 27701:2019

ISO 27701:2019 Privacy Information Management буюу Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартын хэрэгжилтийг хангаж, холбогдох бодлого журамд өөрчлөлт оруулж, өөрчлөлттэй холбоотой сургалт, зөвлөмжийг дотоод ажилтнууддаа тогтмол өгч, шинэ хяналтын процессийг үүсгэсэн. Мөн түүнчлэн эрх бүхий хөндлөнгийн байгууллагаар сертификат баталгаажуулах аудитыг зохион байгуулж, Монгол Улсдаа анхны сертификатыг хангасан байгууллага болсон. Аудитын үр дүнг холбогдох удирдлага, хороодод тайлагнаж тогтмол сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХААН Банк нь Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах олон улсын стандартыг Монгол Улсдаа хэрэгжүүлсэн анхны байгууллага болсон. Уг стандартын дагуу банк нь харилцагчийн буюу хувь хүнийг таних боломжтой мэдээллийг хамгаалах, ямар зорилгоор ашиглагдаж буй эсэхэд хяналт тавих мөн зөвхөн ажлын шаардлагаар аюулгүй ашиглахад чиглэгдсэн холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Мөн стандартын шаардлагуудын хүрээнд холбогдох хяналтуудыг үндсэн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Мэдээллийн аюулгүй байдлын сургалт, зөвлөмж**

Банкны зүгээс хүнээс шалтгаалсан мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэлийг бууруулах, удирдах зорилтын хүрээнд нийт ажилтнууддаа Мэдээллийн аюулгүй байдлын сургалт, зөвлөмжүүдийг хүргүүлдэг ба тогтмол сайжруулан ажилладаг.

Түүний зэрэгцээ, харилцагчдадаа мэдээллийн нууцлалаа хангах, мэдээллээ бусдад алдахгүй, задруулахгүй байх болон банкны карт болон цахим бүтээгдэхүүнүүдийг хэрхэн аюулгүй ашиглах талаарх зөвлөмж, мэдээллүүдийг банкны зүгээс Монголын банкны холбоо, Цагдаагийн ерөнхий газар болон арилжааны бусад банктай хамтран харилцагчдадаа зөвлөмж мэдээллийг тогтмол хүргэдэг.

**Мэдээллийн аюулгүй байдлын технологийн хяналт, үйл ажиллагаа**

Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын төв нь 24/7 буюу бодит цагийн горимоор хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн халдлага, довтолгоог зогсоох, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Банкны системүүд рүү ажилтнуудын хандах үйл ажиллагааг олон улсын аюулгүйн аргачлал, процесс, техник, системүүдээр дамжуулан хэрэгжүүлж, тогтмол хянаж байна. Олон улсын OWASP (Open Web Application Security Project), CVE (Common Vulnerabilities and Exposures), APT (Advanced Persistent Threat) дээр илэрч буй цахим халдлага, зорилтот халдлага, довтолгоонуудыг “Machine Learning”-ийн тусламжтайгаар илрүүлэн таслан зогсоож буй. Банкны систем, сүлжээ, серверүүд болон төгсгөлийн төхөөрөмжүүдэд аюулгүй байдлын шийдлүүдийг нэвтрүүлэн олон улсад тэргүүлэгч, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай хамтран нэвтрэлтийн шалгалтууд “Penetration Testing – Black, White, Gray” болон хяналтуудыг тогтмол хэрэгжүүлэн ажилладаг.

## ДОТООД АУДИТ БА ДОТООД ХЯНАЛТ

### Дотоод аудит

#### Зорилго, чиг үүрэг

Дотоод аудит нь “Банкны засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоонд бодитой байх зарчимд тулгуурласан хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх замаар банкны үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх” зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

Олон улсын дотоод аудиторчуудын институт (ОУДАИ)-ийн Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (ОУМПХ)-ний стандартууд болон ёс зүйн дүрмийг ХААН Банкны дотоод аудит мөрдөн ажилладаг.




International Professional Practices Framework

Банкны дотоод аудит нь 2023 оны 10-р сард олон улсын нэр хүндтэй, тэргүүлэгч байгууллагаар хараат бус чанарын үнэлгээ хийлгэж, Дотоод аудитын дүрэм, бодлого, үйл ажиллагаа нь Дотоод аудитын олон улсын стандарт болон ёс зүйн дүрэмд “бүрэн нийцдэг” үнэлгээ авсан.

#### Бүтэц, зохион байгуулалт

Дотоод аудит нь зорилго болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Компанийн зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлагад харьяалагдаж, Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар дараах бүтэц, зохион байгуулалтаар ажилладаг. Үүнд:



Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилох, Дотоод аудитын дүрэм, стратеги болон жилийн төсөв төлөвлөгөөг батлах, аудитын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг.

Дотоод аудит нь тодорхойлсон зорилго, түүнийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтаараа Банкны бизнесийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны зорилгыг дэмжих, хамгаалахад чиглэн ажиллаж байна.

### Дотоод аудитын үйл ажиллагаа ба тогтвортой хөгжил

ХААН Банкны Дотоод аудит нь олон улсын стандартад нийцсэн, технологид суурилсан, уян хатан дотоод аудитын үйлчилгээ үзүүлэгч итгэлт зөвлөх болоход чиглэсэн Дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

Дотоод аудитын Дунд хугацааны стратеги төлөвлөгөө нь тогтвортой ажлын байр, тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал зэрэг Банкны тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан зорилтуудыг агуулж байдаг. Тайлант хугацаанд Тогтвортой хөгжлийн дараах зорилтыг дэмжин ажилласан байна.

Үүнд:

- Аудитын гүйцэтгэлийг нэг стандартын хүрээнд бэлтгэх, архивлах, гүйцэтгэхтэй холбоотой дотоодын шат дараалсан хяналтыг хэрэгжүүлэх, аудитын үйл ажиллагаанд цахим өгөгдлийн сан үүсгэх зорилготой Аудитын системийг ашигладаг. Үр дүнд нь аудитын үйл ажиллагаатай холбогдон гарах бичиг хэргийн зардлыг 2023 онд 32 хувиар бууруулж, цаасны хэрэглээг бууруулах замаар Хариуцлагатай хэрэглээний зорилтыг дэмжин ажилласан байна.
- Аудитад дэмжлэг үзүүлэх Тайлангийн систем, Тасралтгүй аудит, Зайны аудит зэрэг автоматжуулалтын боломжуудыг ашиглаж, аудитын нөөцийг үр ашигтай удирдах, байгальд ээлтэй ажлын орчин бүрдүүлэх, олон талт болон хүртээмжтэй үйл ажиллагааг бий болгосон дижитал хэлбэрт шилжих зорилт тавин ажиллаж байна.

### Дотоод хяналт

ХААН Банк нь 2021 оноос эхлэн хувьцаа эзэшигчийн хөрөнгийн найдвартай байдлыг хангах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Олон улсын тэргүүн туршлага “COSO Internal control framework”-д суурилсан “ХААН Банкны Дотоод хяналтын бодлого”-г боловсруулж, ТУЗ-өөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах бүтцийг гарган ажиллаж байна.



#### ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн технологид суурилсан дотоод аудитын үйлчилгээ үзүүлэх замаар Банкныг зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлж оролцогч



#### АЛСЫН ХАРАА

Олон улсын стандартад нийцдэг, дижитал технологид суурилсан, уян хатан аргачлалаар дотоод аудитын үйлчилгээ үзүүлэгч итгэлт зөвлөх



#### ҮНЭТ ЗҮЙЛС

- Мэргэжлийн үр чадвар
- Хүндлэл
- Хүсэл тэмүүлэл
- Шударга байдал
- Сайн гүйцэтгэл
- Хамтын хүч

Банк дотоод хяналтын тогтолцоог 5 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд байгууллагын бүх түвшинд Үйл ажиллагаа, тайлагнал, нийцлийн зорилтуудыг биелүүлэхэд чиглэн ажиллаж байна.



## ХААН Банкны дотоод хяналтын тогтолцоо



### ЗОРИЛТ

- Үйл ажиллагаа
- Тайлагнал
- Нийцэл



### БҮРЭЛДЭХҮҮН

- Хяналтын орчин
- Эрсдэлийн үнэлгээ
- Хяналтын үйл ажиллагаа
- Мэдээлэл, харилцаа холбоо
- Мониторингийн үйл ажиллагаа



### ХАМРАХ ХҮРЭЭ

- Байгууллагын түвшинд
- Газар алба
- Үйл ажиллагааны нэгж
- Функц

Банк дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнтэй удирдах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- “ХААН Банкны дотоод хяналтын бодлогыг хэрэгжүүлэх зааварчилгаа”, “Дотоод хяналтын үнэлгээний журам”, “Эрсдэл ба хяналтын үнэлгээний RCM аргачлал” зэрэг баримт бичгүүдийг баталсан.
- Дотоод хяналтын бодлогын хүрээнд банкны хэмжээнд дотоод хяналтын тогтолцооны үнэлгээг 2022, 2023 онд хийж, холбогдох чиглэлүүдэд сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- Банкны бизнес зорилго, зорилтод нөлөөлөх үйл ажиллагаанд хамгаалалтын 2-р шугамын нэгжээс батлагдсан үнэлгээний аргачлалын дагуу хяналтын үнэлгээ хийж, засаж залруулах, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ



ХААН Банк дунд хугацааны стратеги зорилтын хүрээнд банканд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, стресс нөхцөл байдлыг даван гарах хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх, мөн түүнчлэн эрсдэлийн удирдлагыг илүү боловсронгуй болгохоос гадна хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP)” болон “Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ILAAP)”-ыг Базелын тогтолцооны стандартчилгдсан аргачлалд суурилан нэвтрүүлсэн.

Тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл даах чадварыг үнэлэх, цаашлаад гарч болох алдагдлыг тэсвэрлэх өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадварын чадамжийг тодорхойлох, хүндрэлийг даван туулах нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Стресс тестийн бодлого, журам”-ын дагуу сценаруудыг сонгон авч параметруудийг тодорхойлж, стресс тестийг хийдэг. Мөн бизнесийн үйл ажиллагааны тасалдал, осол аваар, тэдгээрийн нөлөөлөл, яаралтай авах арга хэмжээг урьдчилан тооцоолж, шаардлагатай нөөцийг төлөвлөхийн тулд Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөөнүүдийг боловсруулан туршин хэрэгжүүлж байна.

Банк 2023 онд тогтвортой байдалд нөлөө үзүүлэх уур амьсгалын нөлөөллийн эрсдэлийг тодорхойлсон бөгөөд Эрсдэл хариуцсан дэд захирлаас тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын нөлөөллийн эрсдэлийг бууруулах, холбогдох тооцоолол судалгаа хийх ажлын хэсэг гарган нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласан ба 2024 онд “Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого”-доо Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийн тогтолцоог тусгаж оруулахаар төлөвлөөд байна.

Мөн Банкны бизнес зорилго зорилт болон зохицуулагч, эзэлдүүлэгч байгууллагын шаардлагад сөргөөр нөлөөлөх уур амьсгалын эрсдэлийг бага түвшинд байлгах зорилгоор Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд уур амьсгалын нөлөөллийн эрсдэлийг бууруулах 3 лимитийг ТУЗ-өөр батлуулан ажиллаж байна.

## НОГООН ЭХ ҮҮСВЭР

Бид **“Тогтвортой хөгжилд манлайлагч байна”** хэмээн тодорхойлсон үнэт зүйлийнхээ хүрээнд 2023 онд тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаандаа онцгойлон анхаарч, тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэмэгдүүлэн, олон улсын санхүүжүүлэгч байгууллага, зөвлөх компаниуд, Засгийн газар, яам, тамгын газар болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран ажиллаж, цар хүрээгээ улам тэлсэн жил боллоо.

Үүний хүрээнд ХААН Банк тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тусгайлан дэмжин, санхүүжүүлэх зорилгоор хамтран ажиллагч олон улсын

хөрөнгө оруулагч, банк санхүүгийн байгууллагуудаас 2-5 жилийн хугацаатай, нийт 277.8 сая ам долларын урт хугацаат эх үүсвэрийг 2023 онд амжилттай татан төвлөрүүлсэн байна. Үүнд ХААН Банк тогтвортой санхүүжилтээр тэргүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсаас олон улсад болон Монголын хөрөнгийн бирж дээр гаргасан хамгийн анхны ногоон бондуудын санхүүжилтүүдийг онцлон дурдахаар байна.

### Олон улсад гаргасан Ногоон бонд

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын суурь конвенцийн хүрээнд байгуулсан Парисын хэлэлцээрийн дагуу улс орон бүр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтоо тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах зорилт тавиад байгаа бөгөөд тус зорилтыг ХААН Банк өөрийн Тогтвортой хөгжлийн бодлого болон бизнес стратегитэй уялдуулж, олон улсын зах зээлд шинэлэг санхүүжилтийн хэрэгслүүдээр дамжуулан санхүүжилтийн шинэ эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжуудыг эрэлхийлэн ажиллаж байна.

Банк нь 2023 оны 3-р сарын 16-ны өдөр Монгол Улсын анхны Ногоон бондыг олон улсын зах зээлд гаргаж, 5 жилийн хугацаатай 60 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн билээ. Ногоон бондын эх үүсвэр босгох ажлыг ОУСК (IFC)-иас зохион байгуулж, өөрийн эх үүсвэрээс 15 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бол Нидерландын хөгжлийн банк (FMO) 35 сая ам.долларын, АНУ-д төвтэй, байгаль орчин, нийгмийн чиглэлээр хөрөнгө оруулдаг MicroVest компани 10 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн.



ХААН Банк нь Монгол Улсаас анх удаа Ногоон бонд олон улсын зах зээлд гаргасан нь санхүүгийн салбарт шинэлэг санхүүжилтийн хэрэгслийг анхлан нэвтрүүлсэн онцлох үйл явдал болсон. Энэ нь 2022 оны байдлаар Монгол Улсын банкны салбарын нийт зээлийн багцад ногоон зээлийн багцын эзлэх хувь хэмжээ 1.4 хувь байгааг 2030 он гэхэд 10 хувь болгох нэгдсэн зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц болох онцлог санхүүжилт болж өгсөн төдийгүй цаашид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Олон улсын зах зээлд ногоон бонд гаргахын тулд банк Монгол Улсын Ногоон таксаноми, Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA), олон улсын хөрөнгө оруулагч

байгууллагуудын зарчим, шаардлагуудыг үндэслэн банкныхаа “Ногоон бондын санхүүжилтийн хүрээ”-г боловсруулан гаргасан. Тус **“Ногоон бондын санхүүжилтийн хүрээ”** баримт бичигт дурдсан ногоон бондын эх үүсвэрийн зарцуулалтын хүрээнд шаардлага хангасан ногоон төсөл, хөтөлбөрийг сонгох, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос гаргасан ногоон бондын зарчмуудтай (Green bond principles) нийцэж буй эсэхийг байгаль орчин, нийгэм болон засаглал (БОНЗ)-ын үнэлгээ гаргадаг Sustainable Fitch гэх байгууллагаар үнэлүүлэн “САЙН” гэсэн үнэлгээ авсан.

Энэхүү бичиг баримт нь тухайн бондын эх үүсвэрээр санхүүжигдэх үндсэн 7 чиглэлийн ногоон төсөл, хөтөлбөрийг тогтоож өгсөн байдаг.



Сэргээгдэх эрчим хүчний төслүүд



Ногоон барилгын шийдлүүд



Усны менежмент, усны хэмнэлттэй технологи



Ногоон тээвэр



Эрчим хүчний хэмнэлт үүсгэх, бүтээгдэхүүн, үйлчилгээ, төслүүд



Бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа



Тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуй

Дотоодын зах зээлд гаргасан Ногоон бонд

Банкны системийн активын 32%-ийг дангаар бүрдүүлдэг үндэсний хэмжээнд тэргүүлэгч банкны хувьд ХААН Банк байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх ногоон санхүүжилтийн багцаа эрчимтэй нэмэгдүүлэх дунд хугацааны томоохон зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд урт хугацаат эх үүсвэр татахаар дотоодын хөрөнгийн зах зээл дээр 30 сая ам.доллартай тэнцэх хэмжээний ногоон бонд гаргасан. Энэхүү ногоон бондын санхүүжилтээр зөвхөн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, хүлэмжийн хийг бууруулах зорилготой төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэхээрээ онцлог юм.


ХААН Банкны Ногоон бондыг олон нийтэд танилцуулж, Монголын хөрөнгийн бирж дээр анх удаа арилжаалах үйл ажиллагаанд “БиДиСек ҮЦК” ХК үндсэн андеррайтераар, “Хаан Лекс Партнерс” ХХН хууль зүйн зөвлөхөөр, “Эвиденсе Аудит” ХХК хөрөнгийн үнэлгээ, “Прайсуотерхаус Куперс Аудит” ХХК санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр тус тус хамтран ажилласан юм.

ХААН Банк дотооддоо Ногоон бонд гаргаснаар Монголын хөрөнгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийг тэлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Ногоон зээлийн багц

ХААН Банк 2022 оны жилийн эцсийн байдлаар ногоон зээлийн багц 105 тэрбум төгрөг байсан бол 2023 оны эцсээр 377.4 тэрбум төгрөгт хүрч, зээлийн багц 257%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны жилийн эцсээр арилжааны банкууд 800.5 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцыг Монголбанканд тайлагнасан бөгөөд ХААН Банк нийт арилжааны банкуудын ногоон зээлийн багцын 47.1%-ийг дангаар бүрдүүлж байна.



Нийт ногоон зээлийн багцыг Ногоон таксаноми ангиллын дагуу задалж харвал эрчим хүчний хэмнэлт үүсгэх зориулалт 66.7% буюу давамгайлж байгаа бол сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга, тогтвортой хөдөө аж ахуйн ангиллын зээлүүд 27.8%-ийг бүрдүүлж байна.

Ногоон зээлийн багцын задаргаа

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

| Ногоон таксаноми ангилал                                    | Эзлэх хувь |
|-------------------------------------------------------------|------------|
| Сэргээгдэх эрчим хүч                                        | 12.1%      |
| Бохирдол багатай эрчим хүч                                  | -          |
| Эрчим хүчний хэмнэлт                                        | 66.7%      |
| Ногоон барилга                                              | 8.3%       |
| Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа               | 0.8%       |
| Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ                            | 0.6%       |
| Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал | 7.4%       |
| Карбон бага ялгаруулдаг тээвэр                              | 4.1%       |

## НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХААН Банкны хувьд эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, ногоон барилга, ногоон тээвэр, тогтвортой хөдөө аж ахуйн орчин үеийн шийдлүүдийг нэвтрүүлэх, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах замаар сөрөг нөлөөг бууруулах байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх ногоон санхүүжилтийн багцаа эрчимтэй нэмэгдүүлэх дунд хугацааны томоохон зорилтыг хэрэгжүүлж байна.

Энэхүү зорилтын хүрээнд 2023 онд “Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл”, “Ногоон автомашины зээл” болон гэр хорооллын болон зуслангийн айлуудад зориулсан “Амьдрах орчноо сайжруулах” болон “Ногоон бондын хүрээ”-нд тусгагдсан үндсэн 7 ангиллын дагуу төсөл, хөтөлбөрийг дэмжих зорилгоор “Ногоон төслийн бизнесийн зээл”-үүдийг тус тус шинээр нэвтрүүлээд байна.

### Банкны шинээр нэвтрүүлсэн ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

| Зээлийн бүтээгдэхүүн                                                 | Төрөл        | Зээлийн зориулалт, таксономи ангилал                                                                                                                                                                                                                                                                                  | Зээлийн хэмжээ                                                                                                                            | Хугацаа        |
|----------------------------------------------------------------------|--------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| Ногоон төслийн бизнесийн зээл                                        | Бизнес       | <ul style="list-style-type: none"> <li>Сэргээгдэх эрчим хүч;</li> <li>Эрчим хүчний хэмнэлт;</li> <li>Ногоон барилга;</li> <li>Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа;</li> <li>Усны менежмент, хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа;</li> <li>Тогтвортой хөдөө аж ахуй;</li> <li>Эко тээвэр;</li> </ul> | Тухайн төслөөс хамаарна. Зөвхөн сэргээгдэх эрчим хүчний төслийн тухайд зээлийн дээд хэмжээ 5 сая ам.доллартай тэнцэх төгрөгөөс хэтрэхгүй. | 60 хүртэлх сар |
| Цахилгаан тээврийн хэрэгслийн зээл                                   | Иргэд Бизнес | 100% цахилгаан, шинэ тээврийн хэрэгсэл байх                                                                                                                                                                                                                                                                           | Шинэ цахилгаан тээврийн хэрэгслийн үнийн дүнгээс хэтрэхгүй                                                                                | 84 хүртэлх сар |
| Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц худалдан авах зээл (хувьсах)       | Иргэд        | Барилгын эрчим хүчний гэрчилгээ “В” буюу түүнээс дээш үзүүлэлт бүхий барилгууд                                                                                                                                                                                                                                        | 500 сая хүртэлх төгрөг                                                                                                                    | 180 - 240 сар  |
| Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдан авах зээл (хувьсах) |              |                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                           | 120 - 180 сар  |
| Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих зээл (хувьсах)         |              |                                                                                                                                                                                                                                                                                                                       | 80 сая хүртэлх төгрөг                                                                                                                     | 60 хүртэлх сар |
| Амьдрах орчноо сайжруулах зээл                                       |              | Амины сууц, байшингийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчээ хэмнэж, сайжруулан засварлах                                                                                                                                                                                                                            | 80 сая хүртэлх төгрөг                                                                                                                     | 60 хүртэлх сар |



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг  
дэмжих зээл

Банк эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2023 оны 3-р сард хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн шинэ зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулсан билээ. Олон улсын болон дотоодын судалгааны байгууллагуудын хийсэн судалгаагаар эмэгтэй бизнес эрхлэгч зээл авахад тулгардаг гол сорилтуудын нэг нь барьцаа хөрөнгө байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор тус зээлийн бүтээгдэхүүн дээр **“Сайн”** зээлдэгч тохиолдолд барьцаа хөрөнгийн шаардлагыг сулруулах боломжийг бий болгосноороо онцлог юм.

ХААН Банк 2023 онд жендэрийн санхүүжилтийн хүрээнд олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудаас нийт 95 сая ам.долларын эх үүсвэр татан төвлөрүүлсэн бөгөөд эдгээр эх үүсвэрийг бүрэн ашиглаж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулан гаргасан бизнесийн зээлийн бүтээгдэхүүний хувьд жилийн эцсийн байдлаарх багцын хэмжээ 362.1 тэрбум төгрөгт хүрээд байна.



95 сая

ам.долларын эх үүсвэр  
татан төвлөрүүлсэн



362.1

тэрбум төгрөг  
хүрсэн

| Зээлийн бүтээгдэхүүн                                         | Төрөл                                       | Зээлийн зориулалт, таксономи ангилал    | Зээлийн хэмжээ           | Хугацаа        |
|--------------------------------------------------------------|---------------------------------------------|-----------------------------------------|--------------------------|----------------|
| Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан хөрөнгө оруулалтын зээл  | Бичил, ЖДБ эрхлэгч, хувиараа бизнес эрхлэгч | Барьцаа хөрөнгийн шаардлагыг сулруулсан | 1.0 тэрбум төгрөг хүртэл | 36 хүртэлх сар |
| Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан эргэлтийн хөрөнгийн зээл |                                             |                                         | 500.0 сая төгрөг         |                |



### Эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хөтөлбөр

ХААН Банк нь Жижиг дунд бизнесийг дэмжих төвөөрөө дамжуулан харилцагчдаа зориулан бизнесээ амжилттай удирдан чиглүүлэхэд нь шаардлагатай бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн, үйл ажиллагаагаа чадавхжуулах, цар хүрээгээ нэмэгдүүлэх, хөгжлийн шинэ шатанд гарах боломжийг нээж өгөхийг зорьж ажилладаг билээ.

2023 онд 6 хөтөлбөрийн хүрээнд нийт 2009 харилцагчийг сургаж хөгжүүлсэн төдийгүй нийт сургалтад хамрагдсан харилцагчдын 70 хувь буюу 1,400 орчим нь эмэгтэй бизнес эрхлэгч байв. “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” буюу бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн удирдлагын манлайлал, хувь хүний хөгжил, бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлэх замаар бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зорилготой хөтөлбөрт нийт 315 эмэгтэй бизнес эрхлэгчийг хамруулсан байна.



**6** хөтөлбөрийн  
хүрээнд



Сургалтад хамрагдсан  
**2,009**  
харилцагч



**70%** буюу

**1,400** орчим эмэгтэй  
харилцагчид

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### Зээлийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ хийх

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар нийтдээ 915.6 тэрбум төгрөгийн 336 зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээ хийсэн зээлийн багцыг задалж харвал:

- Нийт 746 тэрбум төгрөгийн дүнтэй 316 зээлийн хүсэлтэд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ
- Нийт 114.6 тэрбум төгрөгийн дүнтэй 3 зээлийн хүсэлтэд БОНЗ-ын дэлгэрэнгүй шинжилгээ
- Нийт 54.8 тэрбум төгрөгийн дүнтэй 17 зээлийн хүсэлтэд сүүлийн 12 сард хийгдсэн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг Зээлийн үйл ажиллагааны журмын дагуу хяналт тавин зөвшөөрөл олгосон байна.



### Зээлийн багцын хязгаарлалтад хяналт тавьж ажиллах

1. Архи тамхины үйлдвэрлэл, төрөлжсөн худалдааны бизнесийн салбарт мөрдөх 2.5%-ийн лимит:
  - Нийт 2023 онд 20.3 тэрбум төгрөгийн 50 зээлийн хүсэлтэд судлах зөвшөөрөл өгч ажилласан.
  - Багцын лимитийн гүйцэтгэлийг сар бүр тооцож, Эрсдэлийн удирдлагын хороо, ТУЗ-д тайлагнасан бөгөөд 2023.12.31-ний байдлаар тус салбарын зээлийн багц нийт зээлийн багцын 0.95 % байна.
2. Химийн хорт бодисын үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт тээвэрлэлтийн үйл ажиллагааны салбарт мөрдөх 10%-ийн лимит:
  - Нийт 41.5 тэрбум төгрөгийн 9 зээлийн хүсэлтэд судлах зөвшөөрөл өгч ажилласан.
  - Багцын лимитийн гүйцэтгэлийг сар бүр тооцож, тайлагнасан бөгөөд 2023.12.31-ний байдлаар нийт зээлийн багцад эзлэх хувь 4.99% байна.

### Сургалт, чадавхийг сайжруулах

2023 онд БОНЗ-ын эрсдэлийн удирдлага, үнэлгээний процессын талаарх сургалтын агуулгыг шинэчлэн оны эцсийн байдлаар зээлийн ажилтнууд болон харилцагч нийт 464 хүнд БОНЗ-ын эрсдэлийн удирдлага, үнэлгээний талаар сургалт орсон байна.

### БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын журам, зохицуулалт

Эдийн засгийн салбарын байгаль орчны нөлөөллийн ангиллуудад нэмэлт өөрчлөлт оруулж, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн түвшин болгож, 35 дэд ангиллыг ногоон ангиллаас шар болон улаан ангилал руу буюу үнэлгээ хийгдэх ангилалд шилжүүлж, энэхүү өөрчлөлтийг 2023 оны 3-р сарын 9-ний өдрөөс мөрдлөг болгож ажилласан.

Зээлийн үйл ажиллагааны журам дахь БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний зохицуулалтад “Нарны цахилгаан үүсгүүрийн төслийн нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой болзошгүй эрсдэлийг шалгах маягт”-ыг шинээр нэвтрүүлж, үнэлгээнд ашиглах зохицуулалт нэмж оруулсан.

**2.5%** лимит Архи тамхины үйлдвэрлэл, төрөлжсөн худалдааны бизнесийн салбар

**10%** лимит Химийн хорт бодисын үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт тээвэрлэлтийн үйл ажиллагааны салбар



**20.3 тэрбум**

төгрөгийн 9 зээлийн хүсэлтэд судлах зөвшөөрөл өгч ажилласан.

нийт зээлийн багцад эзлэх хувь  
**0.95%**



**41.5 тэрбум**

төгрөгийн 9 зээлийн хүсэлтэд судлах зөвшөөрөл өгч ажилласан.

нийт зээлийн багцад эзлэх хувь  
**4.99%**


# САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ

## Хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ

Үндэсний тэргүүлэгч банк болохын хувьд ХААН Банк нь банк санхүүгийн салбартаа харилцагчийн үйлчилгээгээр манлайлагч байх өндөр үүрэг хариуцлага хүлээдэг. Бид цахим банкны шинэчлэл, өсөлт дэвшилтэд тулгуурлан салбар тооцооны төв, Харилцагчийн мэдээллийн төв цахим сувгуудаараа дамжуулан харилцагчийн үйлчилгээг улам сайжруулж, Монголдоо тэргүүлэх хэмжээний харилцагч төвтэй байгууллага болох зорилго тавин ажиллаж байна.


## Нийт харилцагч

ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт харилцагч




## Зээлийн багц

ХААН Банкны 2022 ба 2023 оны зээлийн багц гендерээр




## Хадгаламж багц

ХААН Банкны 2022 ба 2023 оны хадгаламжийн багц гендерээр



## Харилцагчдын нас

ХААН Банкны 2022 ба 2023 оны харилцагчдын нас, хүйсээр




## Харилцагчдын харьцаа сегментээр

ХААН Банкны 2023 оны харилцагчдын сегментээр

| Харилцагчдын сегмент   | Нийт харилцагчдын тоо | Хувь   |
|------------------------|-----------------------|--------|
| Приорити               | 7,658                 | 0.27%  |
| Сигначер               | 44,670                | 1.57%  |
| Байгууллага            | 58,110                | 2.04%  |
| ЖДБ                    | 5,479                 | 0.19%  |
| Төрийн байгууллага     | 104                   | 0.00%  |
| Санхүүгийн байгууллага | 384                   | 0.01%  |
| Иргэн                  | 2,737,513             | 95.92% |




ХААН Банкны 2023 оны харилцагчдын харьцаа байршлаар




### Цахим банк хэрэглэгчдийн тоо

ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт цахим банк хэрэглэгчдийн тоо хүйсээр




### Интернэт банк хэрэглэгчдийн тоо

ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт интернэт банк хэрэглэгчдийн тоо хүйсээр



### Мобайл банк хэрэглэгчдийн тоо

ХААН Банкны 2022 ба 2023 оны нийт мобайл банк хэрэглэгчдийн тоо хүйсээр



## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Банк тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байхын тулд харилцагчдаа санхүүгийн мэдлэг мэдээллээр тасралтгүй ханган санхүүгийн боловсролтой болгох нь хамгаас чухал юм.

Энэ ч утгаараа ХААН Банк харилцагчдад санхүүгийн боловсролын мэдлэг мэдээллийг тогтмол олгох, цаашлаад санхүүгийн аюулгүй, тогтвортой байдлыг дэмжихээр дараах ажлуудыг 2023 онд зохион байгуулж ажиллалаа.



### Олон нийт рүү чиглэсэн ажлууд

Банкны цахим сувгуудаар дамжуулан хуримтлал үүсгэхийн ач холбогдол, санхүүгийн дархлаа, хүсэл, хэрэгцээгээ ялгах зэрэг сэдвийг агуулсан “Нэмые” цуврал, хувийн мэдээллээ цахим орчинд хамгаалах, цахим луйвраас өөрийгөө сэргийлэх зэрэг сэдвээр харилцагчдад анхааруулга өгөх reels зэрэг контентуудыг бэлтгэн түгээж ажиллалаа.

Мөн MGL радиогийн “Радио нэг дусал” болон “Радио хөтөч” нэвтрүүлэгт санхүүгийн боловсролтой холбоотой сэдвүүдийг оруулж иргэд, олон нийтэд сонирхол татахуйц, мэдлэг болохуйц мэдээллүүдийг өгч ажилласан.


### Хувийн санхүү, хуримтлалын тухай сургалтууд

Харилцагч байгууллагуудаас ирсэн хүсэлтүүдийг харгалзан тэдний нас, хүйс, мэргэжлийн онцлог, боловсролын түвшин зэрэгт үндэслэн хувь хүний санхүү, хөрөнгийн зах зээл, урт хугацааны хуримтлал, тэтгэврийн хуримтлал зэрэг мэдээллийг багтаасан сургалтыг танхимаар зохион байгуулсан бол ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мөнгөтэй харьцах урлаг, санхүүгийн мөчлөг, хуримтлуулах дадал зэрэг сэдвээр сургалт орсон.

### Бусад байгууллагатай хамтарсан аян

2023 онд Монголбанк, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассе банкны Монгол дахь сан, арилжааны банкуудтай хамтран “Дэлхийн мөнгөний долоо хоног-2023” аяны хүрээнд хувь хүний санхүүгийн хандлагыг төлөвшүүлэх, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдалд хувь нэмрээ оруулдаг байх зөв дадал, хэвшлийг уриалахад чиглүүлж, Монгол орон даяар тархсан 540 гаруй салбар нэгжээрээ дамжуулан нийт 12,440 орчим хүүхэд залуус, 49,000 орчим иргэнд шууд болон шууд бусаар хүрч ажилласан.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассе банкны Монгол дахь сан, Зээлийн батлан даалтын сан, арилжааны банкууд болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран жил бүрийн 10-р сард болдог “Дэлхийн хуримтлалын өдөр-2023” аяны хүрээнд хүүхэд залуус, эцэг эхчүүд болон залуу гэр бүлүүдэд мөнгөө зөв удирдах, хуримтлал үүсгэхтэй холбоотой мэдлэг, ойлголтыг түгээн, банкны хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан ажилласан юм. Уг аяны хүрээнд нийт 14,000 орчим иргэн, хүүхэд залууст мэдээ мэдээлэл хүргэж ажилласан байна.



## ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Банк нь харилцагчид цахим, ногоон санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн сацуу бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаандаа Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмэр оруулах, эерэг өөрчлөлт бүхий санал санаачилгуудыг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээсээр байна. Олон улсын Moody's үнэлгээний байгууллагын зөвлөмжийн хүрээнд дотоод үйл ажиллагаандаа олон санал санаачилга, ажлыг нэвтрүүлээд байна. Уур амьсгалын өөрчлөлт бидний ажил, амьдралын хэв маягт ихээхэн нөлөө үзүүлэх болсонтой холбоотой түүнээс үүдэн гарах эрсдэл, мөн дасан зохицож, сөрөг нөлөөг бууруулах зайлшгүй шаардлага тулгарч буй. Үүний тулд ХААН Банк үйл ажиллагааныхаа хүрээнд санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлүүдийг тодорхойлж, шат дараатай ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхээр зорьж байна. Түүнчлэн тогтвортой ажлын байрыг хадгалж, ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, байгаль орчин, хүндээ ээлтэй ажлын орчныг бий болгоход анхаарлаа хандуулж ирлээ.

## ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР

### Ажилтны сэтгэл ханамж

Байгууллагын амжилтад олон хүчин зүйлс нөлөөлдгийн нэг нь ажилтныхаа дуу хоолойг сонсох явдал юм. Тиймээс бид 2017 оноос хойш “Ажилтны судалгаа”-г хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж ирсэн. Судалгаанаас гарсан үр дүн бүрийг бид нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийн шат, шатны удирдлагуудад танилцуулдаг төдийгүй цаашид анхаарч сайжруулахаар ажилдаа тусган хэрэгжүүлдэг билээ.

Өмнөх жилүүдийн судалгааны үр дүнд үндэслэн бид сүүлийн 5 жилийн хугацаанд томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнээс дурдвал:

### Сургалт, хөгжил

Сэтгэл зүйн эрүүл мэнд, Амжилтын 6 зан төлөвийн цахим сургалт, Борлуулалт-харилцаа-зөвлөхийн үр чадвар олгох сургалт, “Ёс зүйтэй банкир”-ын цуврал сургалт, “Дижитал банкир” төслийг тус тус амжилттай хэрэгжүүллээ. “SEED 2” мэдлэг хуваалцах хөтөлбөрийн 12 цахим сургагч багшийн сургалтыг цахимжуулсан бөгөөд үүнд 2788 ажилтан цахимаар хамрагдсан бол танхимын 21 удаагийн давтамжит сургалтад 765 ажилтныг хамрууллаа. Ажилтнуудын тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гар утасны Erdem app-ийг хөгжүүлж нэвтрүүллээ.

### Байгууллагын соёл

“Цахим банкир” болох стратеги, чиглэлийн хүрээнд ХААН Банкны нэгдмэл соёлын үндэс болсон “Ажилтнуудын эрхэмлэдэг 5 зан төлөв”-т “Цахим сэтгэлгээтэй байх” зан төлөвийг багтааж 6 зан төлөвтэй болсон. Үүнтэй холбогдуулан 5 дэд захирлаар удирдуулсан баг шинээр нэмэгдсэн зан төлөвийг таниулах аяныг сар бүр амжилттай өрнүүллээ. Мөн ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор “Ёс зүйтэй банкир” төслийг 3 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн.

### Ажлын гүйцэтгэл

Жил бүрийн ажилтны судалгааны гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой санал, хүсэлтүүдэд тулгуурлан “Ажилтны гүйцэтгэлийн удирдлагын журам”-ыг шинэчилсэн. Шинэ журмаар ажилтны гүйцэтгэлийг удирдах, тасралтгүй сайжруулах, ажилтны хувийн хөгжлийг дэмжих, хангалтгүй гүйцэтгэлийн үед гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх үр дүнтэй харилцааг зохицуулах боломж бүрдээд байна. “Гүйцэтгэлийн зорилго зорилтыг OKR аргачлалаар үр дүнтэй тодорхойлох”, “Гүйцэтгэлийн явцын уулзалтыг үр дүнтэй хийх, фийдбайк өгөх” сургалтыг нийт удирдах ажилтан, ахлах ажилтнууд болон нийт ажилтнуудад танхим болон цахимаар зохион байгуулсан.

### Цалин, урамшуулал

Зах зээлийн нөхцөл байдал, өнгөрсөн жилийн судалгааны үр дүнг харгалзан 2023 онд хоёр удаа ажилтнуудын цалинг нэмэгдүүлсэн. Ингэхдээ банкны нийт цалингийн санг 2023 оны 5-р сард 10.5 хувиар, 2023 оны 10-р сард 20.2 хувиар тус тус өсгөсөн байна.

### Ажилтны ажил-амьдралын тэнцвэр

ХААН Банкны ажилтны ажлын уян хатан зохицуулалтын тухай журам, Shared office концепцийн дагуу ажилтнууд зайнаас, гэрээс, уян цагаар ажиллах боломж бүрдсэн. 2023 оны 1-р сараас эхлэн банкны зүгээс ажилтнууддаа нэмж олгодог цалинтай амралтын төрөлд “Гэр бүлийн амралтын өдөр”-ийг нэмсэн. Ингэснээр ажилтнууд маань ХААН өдөр, Төрсөн өдөр, Гэр бүлийн амралтын өдөр гэсэн цалинтай 3 амралтын өдөртэй болсон. Ажилтнуудынхаа дунд спортын өдөрлөг, эвент арга хэмжээг шинэлэг хэв маягаар зохион байгууллаа. Тухайлбал, спортын өдөрлөгт 2023 оноос Crossfit, гэр бүлийн тэмцээн зэргийг шинээр нэмсэн. “White Festival inspired by HR” фестивалийг өргөн цар хүрээтэй зохион байгуулж, ажилтнуудаасаа талархлын үгс хүлээн авлаа. Жуков оффист хүүхдийн өрөө тохижуулан мэргэжлийн багшийн удирдлага дор үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарах зорилгоор гэрээт сэтгэл зүйчтэй хамтран ажиллаж байна. Мөн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжихээр Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх “Бэст массаж” төвтэй хамтран бариач нарыг ажиллуулж байна. Ажилтнуудаа эрүүл мэндийн даатгал, гэнэтийн ослын даатгалд хамруулсан.



### Ажилтны сургалт хөгжил

Ажилтныг сургахаас суралцах сэтгэл зүйтэй болох шилжилтийг дэмжиж, цаашид мэдлэг туршлагаа хуваалцах арга барилыг хөгжүүлэх, цахим соёл, сэтгэлгээг таниулах чиглэлд нийт ажилтнуудыг хамруулсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, цахим сургалтын арга барил руу төвлөрч ажиллав.

Иймээс Монголын өнцөг булан бүрд ажиллаж амьдарч буй нийт ажилтнуудынхаа сургалт хөгжлийн үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй, уян хатан, хэрэгцээнд суурилсан, тасралтгүй суралцах боломжтой байхад анхаарч төрөл бүрийн сургалтууд санал болгодгоос ажилтнуудад чөлөөт цагаараа суралцах боломж олгож нээлттэй хувилбар болох ERDEM платформыг нэвтрүүлсэн.

Дотоодын цахим сургалтын платформ (KB Academy)-оор дамжуулан ижил стандартын сургалтуудыг орон зайнаас үл хамааран ажилтнууддаа тасралтгүй суралцах боломж олгож байна. Ажилтан өөрийн албан тушаалд зориулан суралцахаас гадна цаашдын карьерт тохирох ур чадвараа ч нэмж хөгжүүлэх боломжтой. 2023 онд ажилтныхаа хувийн хөгжилд зориулан хамтран ажиллагч 4 байгууллагын контентийг байршуулснаас гадна 232 дотоодын сургагч багшийн 194 гаруй мэргэжлийн сургалт, контентийг бэлтгэж “KB Academy”-аар дамжуулан давхардсан тоогоор 80,470 удаагийн үзэлт, хандалттай сургалт орлоо.

Онцлох контентоос дурдвал, “Employee Experience” цогц сургалт, “Ёс зүйтэй банкир”, “Сэтгэл зүйн эрүүл мэнд зөвлөгөө”, дата скүүл, Tomyo skill-ийн хувь хүний хөгжлийн сургалтууд гэхчилэн ажилтан өөрийн чөлөөт цагаар суралцахыг хүссэн сэдвээрээ хичээл үзэх боломжтой.

2023 онд мэргэжлийн, хувь хүний хөгжлийн сургалтуудыг бид бүтэн жилээр төлөвлөж, нийт 413 удаагийн сургалтад давхардсан тоогоор 5,810 ажилтныг хамрууллаа.

### MAP хөтөлбөр

Дараагийн түвшний удирдах ажилтнуудыг бэлтгэх зорилгоор 2023 оны 9-р сараас “MAP” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 46 ажилтан хамрагдаж, үүнээс 23 эмэгтэй ажилтан бэлтгэгдэж байна.

### Манлайллын сургалт (Excellence 1 & 2)

Таван модуль бүхий дотоод манлайллын “Excellence интерактив” хөтөлбөрт 21 удирдах ажилтан, долоон модуль бүхий “Growing together” интерактив хөтөлбөрөөр иргэдийн банкны удирдах ажилтнуудыг сургах 23 сургагч багшаар дамжуулан 5 удаагийн цогц сургалт явуулж, 79 удирдах ажилтан тус тус хамрагдсан.

### Ажлын байран дээрх коучинг хөтөлбөр

Менторинг, коучинг хөтөлбөрийг Pilot төвтэй хамтран явуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд оролцогчид Ментор, Ментий, Коуч, Коучий тус бүр явцын уулзалт тус бүр 3 удаа хийж давтагдсан тоогоор 57 ажилтан хамрагдсан.

### Гүйцэтгэх удирдлагын коучинг хөтөлбөр

Манлайллын ТОП менежер болох 11 алхам сургалтад Гүйцэтгэх удирдлагууд болон дунд түвшний 23 ажилтныг хамруулснаас 9 нь эмэгтэй ажилтан байсан.

### Олон улсын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр

Гадаадын их, дээд сургуулийн магистрын хөтөлбөрт суралцаж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын зэрэгтэй болох, цаашид банканд үнэтэй хувь нэмэр оруулах чадварлаг боловсон хүчин болоход нь дэмжиж, оюуны хөрөнгө оруулалт хийхээр 2023 оноос олон улсын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг эхлүүлж, 2 удирдах ажилтныг Япон, Австрали улсад суралцахад нь тэтгэлэг олголоо.

### Дотоодын их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр

Дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд бакалавр, магистрын зэргээр суралцаж мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд нь ажилтнуудаа дэмжих, оюуны хөрөнгө оруулалт хийхээр 2013 оноос тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Шилдэг талант ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор дотоодын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт нийт 31 ажилтныг шалгаруулан амжилттай хамруулав.

### Суралцагч байгууллага (Learning organization):

“ХААН Банк нь өөрөө бүхэлдээ суралцах орчин юм”

ХААН Банкны нийт ажилтны дундаж ажилласан жил нь 8 жил байдаг тул энэ нь туршлагатай нэгнээсээ, хамт олноосоо суралцах боломж олгодог. Үүнээс гадна бид эдгээр мэдлэг туршлагаа бусадтай хуваалцуулах зорилгоор тусгайлан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

- **Seed хөтөлбөр** - 2023 оны хувьд 24 шинэ сургагч багш нарыг бэлтгэж, танхимын болон цахим сургалтыг бэлтгэн орсоор байна.
- **Mentoring program** - Шинээр томилогдсон удирдах ажилтанд ментор заавал томилж өгдгөөс гадна талант ажилтнуудад зориулан “Pilot Менторинг” хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж 10 ажилтан бэлтгэсэн. Энэхүү хөтөлбөрийг хамрах хүрээ, зорилтод бүлгийг өөрчлөн жил бүр туршлага судлан хэрэгжүүлсээр байна.
- **Knowledge sharing** - Олон улсын төсөл, хөтөлбөр эсвэл сургалтад хамрагдаад ирсэн ажилтнууд бусдадаа мэдлэгээ заавал хуваалцдаг боломжийг бүрдүүлэхээс гадна “SEED 2” мэдлэг хуваалцах хөтөлбөрийн 12 цахим сургагч багшийн сургалтыг цахимжуулан 2788 ажилтан хамрагдаж, танхимын 21 удаагийн давтамжит сургалтад 765 ажилтан хамрагдсан.
- **Олон улсын төслийн аргачлал** - Six Sigma, Agile transformation, Ameyo, CRM гэх мэт олон улсын төслийн аргачлалуудыг ашиглан газар нэгж бүрээс төслийн баг бүрдүүлж, харилцан суралцах боломжийг бий болгодог.
- **LinkedIn Learning** - Монгол Улсаас анх удаа “Outstanding Learning Culture Award”-ыг ХААН Банканд олгосон нь бидний цахимаар тасралтгүй суралцсан амжилтыг бататгасан үйл явдал байв. Олон талын мэдлэгийг хамарсан сэдэв, чиглэлийн дагуу дэлхийн түвшний багш, лекторуудын хичээлийг хүссэн цагтаа, гар утас, компьютер ашиглан үзэж, өөрийгөө тогтмол хөгжүүлэх боломжийг давхардсан тоогоор 700 гаруй ажилтанд олгосон.

### Smart office & Remote employee (Зайны ажилтны шинэ хөтөлбөр)

Уг төсөл нь Банкны тогтвортой хөгжлийн дэд зорилт болох тогтвортой ажлын байрыг хангах хүрээнд цахим шилжилтээс үүсэж гарсан ажлын байрны илүүдлийг зөв оновчтойгоор хуваарилан үр дүнтэй ажиллуулах тогтолцоог бий болгосон. Үүний үр дүнд ажилтан бүр сэтгэл ханамжтайгаар орон зай, бүс нутгаас үл хамааран ажил үүргээ гүйцэтгэх, өсөж дэвжих, өөрийгөө хөгжүүлэх ажлын байраар бүрэн хангагдаж, цахим шилжилтэд бэлэн байх, дасан зохицох соёлыг банк даяар бүрдүүлсэн. Орон нутгийн нийт 1600 гаруй ажилтан төсөлд хамрагдаж, ажлын байрны өөрчлөлтөд орсноор сэтгэлгээгээ өөрчилж чадсан бөгөөд 260 гаруй ажилтан 10 төрлийн ажлын байранд зайнаас ажиллаж байна.

КВ академи цахим сургалтын платформд “Зайны ажилтан бэлтгэх хөтөлбөр” боловсруулж, ажилтан өөрөө сурч хөгжих боломжийг нээж 12 төрөлд хуваан 36 цагийн 48 сургалтын материал байршуулсан. Давхардсан тоогоор 3504 ажилтан цахимаар суралцсан байна.



### “Тогтвортой хөгжилд манлайлагч” аян

Банкны “Тогтвортой хөгжилд манлайлагч” үнэт зүйл болон ТХ-ийн бодлогын тухай нийт ажилтнуудад ойлголт өгөх, хоногшуулах зорилгоор 3 сарын хугацаанд ажилтнууд руу чиглэсэн ажлуудыг таниулан хүргүүлээд байна. Уг аяны хүрээнд нийт ажилтнуудад тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг олгох сургалтыг КВ академи онлайн сургалтын дотоодын платформд заавал үзэх сургалтад багтаасан.

| Сургалт                                                         | Үзэлтийн тоо  | Нийт үзсэн ажилтны тоо | Хувь*  |
|-----------------------------------------------------------------|---------------|------------------------|--------|
| Тогтвортой хөгжил гэж юу вэ?                                    | 13,855        | 3,870                  | 79.9 % |
| Тогтвортой хөгжил олон улсад болон Монголд                      | 7,666         | 2,872                  | 58.6 % |
| ХААН Банкны Тогтвортой хөгжлийн түүхэн замнал, засаглалын тухай | 6,308         | 2,490                  | 50.8 % |
| ХААН Банк сангийн тухай                                         | 3,113         | 1,431                  | 29.2 % |
| ТХ-ийн талаарх шинэ ажилтны сургалт                             | 65            | 18                     |        |
| <b>Нийт</b>                                                     | <b>31,007</b> | <b>10,681</b>          |        |

Аяны өндөрлөх ажлын хүрээнд ажилтнууддаа зориулж ТХ-ийн тухай хөгжөөнт Kahoot тэмцээнийг ажилтнуудын дунд зохион байгуулж, ТХ-ийн талаарх санал зөвлөмжүүдийг ажилтнуудаас хүлээн авч Тогтвортой хөгжил гэх ойлголтыг түгээн хуваалцлаа.

### Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ХААН Банкны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого нь банкны харилцагч, зочинд үйлчлэх, харилцах аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд үйлчлэх бол ХАБЭА-н журам нь банкны ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахтай холбоотой хүрээнд үйлчилнэ.

Зорилтууд:

- Хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, эрүүл ахуйн журам, зааврыг батлах;
- Ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, холбогдох мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгөх;
- Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, арилгах зорилготой эрсдэлийн үнэлгээ хийх;
- Ажилтныг сургалт, мэдээлэл зөвлөмжөөр хангах;

### Хөдөлмөрийн эрх ба олон янз байдал

“Хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого”-д хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд эрх тэгш, олон талт ялгаатай байдлыг хангах, хүн бүрийг хүндлэх, оролцоог дэмжих, аливаа төрлийн ялгаварлал, хавчин гадуурхалт, бусдын нэр хүндийг санаатайгаар унагах буюу гүтгэн гүжирдэх (үүгээр хязгаарлагдахгүй) зэрэг тэвчишгүй хэлбэрээс ангид орчин бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах замаар урт хугацааны тогтвортой ажлын байрыг бий болгох зорилтын хүрээнд ХААН Банкны баримтлах зарчмуудыг тодорхойлсон болно.

### Олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх хандлага

Ажлын байранд ялгаварлан гадуурхалт, дарамтгүй, эрх тэгш байдлыг хангах үүднээс “Ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслах зогсоох, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”, “ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого” зэрэг баримт бичгүүдийг шинээр батлан дагаж мөрдөж эхлээд байна. Мөн хүүхэд асрах чөлөөнөөс эргэн ажилдаа орж буй ажилтнуудад зориулан ажилдаа дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Welcome back” хөтөлбөрийг хэрэгжүүлээ.

### Diversity, Equity and Inclusion

Олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, ойлгох, дэмжих үүднээс ХААН Банк академи чанартай, судалгаа шинжилгээтэй сургалтыг нийт ажилтнуудад хүргэхийг эрмэлздэг. Энэ хүрээнд:

### “Welcome back” хөтөлбөр

2023 оны 6-р сарын 15-наас эхлэн хүүхэд асрах чөлөөнөөс эргэн ажилдаа орж байгаа ажилтнуудаа ажилдаа дасан зохицоход зориулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд 161 эмэгтэй ажилтан хамрагдсаны 29 нь анхан болон дунд түвшний ажилтнууд байна.

Тэгш байдлын тухай ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг хамарсан цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулан бэлтгэлээ.

- “Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, төрөл, харилцах арга зүй” 2023 онд танхим – 23 ажилтанд
- Дохионы хэлний цахим хичээл – 1153 ажилтан үзээд байна.

Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг нийт ажилтнуудад хүргэх тус сургалтын хүрээнд 2023 онд цахим цогц сургалтыг бэлтгэн хүргэсэн нь тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжиж буй юм.

Хүний нөөцийн дата

Нийт ажилтан

ХААН Банкны нийт ажилтны харьцаа байршлаар

|                                                                                           | Орон нутаг | Төв банк | Улаанбаатар |
|-------------------------------------------------------------------------------------------|------------|----------|-------------|
|  Эрэгтэй | 23%        | 36%      | 18%         |
|  Эмэгтэй | 77%        | 64%      | 82%         |

Албан тушаал


ХААН Банкны нийт ажилтны харьцаа албан тушаалаар

|                                                                                             | Гүйцэтгэх удирдлага | Захирал/ менежер | Бусад | Нийт |
|---------------------------------------------------------------------------------------------|---------------------|------------------|-------|------|
|  Эрэгтэй | 64%                 | 32%              | 26%   | 27%  |
|  Эмэгтэй | 36%                 | 68%              | 74%   | 73%  |





ХААН Банкны нийт ажилтны харьцаа төрлөөр



### Шинэ ажилтан

ХААН Банкны шинэ ажилтны хүйсийн харьцаа



# ТОГТВОРТОЙ АЖЛЫН ОРЧИН

## Ногоон оффис

Банкны оффист сэргээгдэх эрчим хүч нэвтрүүлэх


ХААН Банк Сөүл оффис болон орон нутгийн салбар нэгжийн барилгууддаа нарны эрчим хүчний системийг суурилуулаад байна. Нарны эрчим хүчийг хэрэглээд зогсохгүй тухайн барилгыг эрчим хүч үйлдвэрлэгч болгон хувиргадаг BIPV болон BAPV системийг хослуулсан шийдэл нэвтрүүлсэн нь 16.7 тонн нүүрс түлэхээс сэргийлж, Улаанбаатар хотын утааны асуудлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулаад байна.

|                                     | Өдөрт  | Сард      | Жилд       |
|-------------------------------------|--------|-----------|------------|
| Сөүл оффис нийт цахилгааны хэрэглээ | 770кВт | 23,100кВт | 277,200кВт |
| BIPV систем (дундаж үзүүлэлт)       | 77кВт  | 2299.4кВт | 27,593кВт  |
| BAPV систем (дундаж үзүүлэлт)       | 77кВт  | 2299.4кВт | 27,593кВт  |
| Нийт                                | 154кВт | 4,599кВт  | 55,186кВт  |

 **43.6тн**  
CO<sub>2</sub> бууруулсантай тэнцэнэ.

 **3,000**  
мод тарьсантай дүйцнэ.

 **17тн**  
нүүрс түлэхээс сэргийлнэ.



### BAPV систем

BAPV system (Building Applied Photovoltaics) нь нарны эрчим хүч хуримтлуулдаг фотофилм материалыг хавтан дээр суурилуулах байдлаар толь үүсгэж хуримтлуулдаг “Уламжлалт” технологи юм.

### BIPV систем

BiPV system (Building Integrated Photovoltaics) нь нарны эрчим хүч хуримтлуулдаг маш нимгэн фотофилм материалыг шилний завсар суулгах байдлаар “Шилэн панел” үүсгэдэг шинэ технологи

Сөүл оффис, Улаанбаатар хот

Орон нутгийн нэгжийн барилгуудад BAPV систем буюу нарны панелийг тодорхой тоо ширхгээр суурилуулах шийдлийг судлан тус шийдлээр гүйцэтгэх нь орон нутгийн онцлогт тохиромжтой гэж дүгнэсэн. Системийн хувьд All in one систем буюу цэнэг удирдагч, инвертер болон баттерей гэсэн 3 төхөөрөмжийг 1 төхөөрөмжид нэгтгэсэн, нэгжийн аль ч хэсэгт байршуулах боломжтой зай талбай бага эзлэх системийг сонгон суурилуулсан. 2023 онд 5 тооцооны төвд нэвтрүүлсэн байна.



| Суурилалт хийгдсэн нэгжүүд | Барилгын талбайн хэмжээ | Нэгжийн цахилгаан хэрэглээ | Нарны системийн хүчин чадал | Ашиглалтад орсон огноо | Ашигласан хоног | Гүйцэтгэл | Со2 бууруулсан хэмжээ | Мод тарих хэмжээ | Нүүрс шаталт үүсгэх хэмжээ |
|----------------------------|-------------------------|----------------------------|-----------------------------|------------------------|-----------------|-----------|-----------------------|------------------|----------------------------|
|                            | (м2)                    | (Квт.Ц)                    | (Квт.Ц)                     |                        |                 | (Квт.Ц)   | (Тн)                  | (Ш)              | (Тн)                       |
| Лүн                        | 131                     | 5                          | 7                           | 2023.08.25             | 128             | 2001      | 1.57                  | 108              | 0.6                        |
| Хархорин                   | 131                     | 6                          | 7                           | 2023.08.19             | 135             | 2350      | 1.74                  | 120              | 0.67                       |
| Алтанбулаг                 | 108                     | 5                          | 7                           | 2023.09.09             | 121             | 1190      | 0.89                  | 61               | 0.34                       |
| Баянчандмань               | 198                     | 4                          | 7                           | 2023.09.16             | 106             | 828.2     | 0.59                  | 41               | 0.23                       |
| Айраг                      | 108                     | 4                          | 7                           | 2023.09.23             | 99              | 810.9     | 0.59                  | 41               | 0.23                       |
| Нийт                       |                         |                            |                             |                        | 7180.4          | 5.69      | 391                   | 2.19             |                            |

GEELY  
GEOMETRY C

2



### Цахилгаан автомашин банкны хэрэглээнд нэвтрүүлэх

Монгол Улсын агаарын бохирдол, хүлэмжийн хийг бууруулах санаачилгад эерэг хувь нэмэр оруулах зорилгоор банкны үйл ажиллагаанд цахилгаан автомашиныг нэвтрүүлээд байна. Байгаль орчин, эдийн засгийн хэмнэлттэй сонголт хийж цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автомашиныг цэнэглэх түгээгүүр байршуулах ажлууд хийгдээд байна. Ажилтнуудын өдөр тутмын гадуур уулзалт болон хурал цуглааны хувьд цахилгаан автомашинаар зорчих нь нийгэм ба байгаль орчиндоо ээлтэй сонголтыг түгээж үлгэрлэн манлайлж байна.



**100%**  
баттерей



**500км**  
хүртэл туулна.

**100%**  
баттерей

**8цаг**  
цэнэглэхэд

**60квт**  
цахилгаан буюу

**16,170**  
төгрөг зарцуулна.

Цахилгаан автомашины баттерей нь 60кВт, цахилгаан цэнэглэгч 7.2 кВт нийт цэнэглэх хугацаа 8 цаг байдаг.

Цахилгаан автомашин 0% -100% хүртэл цэнэглэхэд 60кВт буюу 16,170 төгрөг зарцуулна.

100% цэнэгтэй цахилгаан автомашин нь замын нөхцөл, цаг агаар, даацаас хамааран 400-500 км туулах нормтой.

2023 оны турш шатахууны 3 удаагийн хомсдол, тэгш, сондгой дугаарын 2 удаагийн хязгаарлалтын үед хэвийн ажилласан нь бизнесийн тасралтгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

TESLA Y  
**3**



## Нийлүүлэлтийн сүлжээний удирдлага

### Худалдан авалтын бодлого

Тогтвортой хөгжлийн бодлогын зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд бэлтгэн нийлүүлэгчийг үнэлэх, бараа бүтээгдэхүүний чанар шаардлагын шалгуурт тусгах Худалдан авалтын бодлогыг чиглүүлэн ажиллаж байна.

Ханган нийлүүлэгчийг сонгохдоо тогтвортой буюу нийгмийн хариуцлагын талаарх шалгуурын авдаг бөгөөд тухайн шалгуурыг хангаж буй нийлүүлэгчийн эрсдэлийн түвшин бага гэж үнэлэгдэх, мөн сонголтод нөлөөлдөг. Нийт 480 нийлүүлэгчээс худалдан авалт хийснээс 410 нь дотоодын харилцагч байна.

Банкны бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх, худалдан авалт хийж байгаа бараа материал, үндсэн хөрөнгө нь Тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн байхад чиглэдэг.

Үүнд:

- Цахилгаан эрчим хүчний хэмнэлт үзүүлэхэд чиглэн төв оффис, салбар нэгжүүдийн стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд ISO стандартыг хангасан цахилгааны хэмнэлттэй лед сүүн гэрэл, эрчим хүч хэмнэх горимд шилждэг цахилгаан бараануудыг бэлтгэн нийлүүлсэн.
- Байгаль орчинд аюултай хог хаягдлыг бууруулах чиглэлд баттерейтэй компьютерийн гар, мауз ашиглахаас татгалзаж, баттерейгүй утсан болгож агуулахын нөөцийг бүрдүүлсэн.
- Ногоон шалгуурын дагуу хангамж бүтээгдэхүүн үйлчилгээ авах чиглэлд хүний биед үзүүлэх тоос, харшлын нөлөө багатай ISO стандарт хангасан бичгийн цаас, цавуу бичиг хэргийн материал, эко бүтээгдэхүүн хэрэглэж байна.
- Төв оффис, салбарын байрыг эко, хүртээмжтэй болгох чиглэлд эргономик бүтэцтэй сандал, эко фундермакс хавтан, дуу чимээ багасгах эсгий хавтан, ажилтны эрүүл аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэхэд чиглэн ажилтнуудын компьютерт нүдний хараанд тохирсон хэмжээтэй дэлгэц худалдан авч суурилуулсан зэрэг ажлыг дурдаж болно.

## Нөөцийн зохистой ашиглалт

| Бүтэц       | Цаасны хэрэглээ (Бичгийн А4, АТМ, ПОС, Дугаарлагч цаас, мөнгөний бүс цаас, баримтын хавтас цаас) |                      |                |                      |                |                      |                |                      |
|-------------|--------------------------------------------------------------------------------------------------|----------------------|----------------|----------------------|----------------|----------------------|----------------|----------------------|
|             | 2020                                                                                             |                      | 2021           |                      | 2022           |                      | 2023           |                      |
|             | ширхэг                                                                                           | үнэ                  | ширхэг         | үнэ                  | ширхэг         | үнэ                  | ширхэг         | үнэ                  |
| Төв банк    | 1,035,327                                                                                        | 473,758,545          | 21,617         | 46,663,183           | 27,681         | 208,962,435          | 9,305          | 85,727,340           |
| Салбар нэгж | 805,953                                                                                          | 976,955,884          | 775,601        | 970,414,779          | 855,646        | 1,194,357,116        | 975,564        | 1,652,089,010        |
| <b>Нийт</b> | <b>1,841,280</b>                                                                                 | <b>1,450,714,429</b> | <b>797,218</b> | <b>1,017,077,962</b> | <b>883,327</b> | <b>1,403,319,551</b> | <b>984,869</b> | <b>1,737,816,350</b> |

Цаасанд зарцуулсан тоо ширхгийн хувьд 2020 оныг 2023 онтой харьцуулахад 2 дахин буурсан ч ханш үнийн өсөлттэй холбоотой үнийн дүн нэмэгдсэн байна. Төв банкны цаасны хэрэглээ жил ирэх тусам буурч байгаа бол салбар нэгжүүдийн хувьд киоск машинд зарцуулах цаасны хэмжээ ихэссэнтэй холбоотой юм.

2021 онд Ковидын хөл хориотой холбоотой цаасны зарцуулалт буурсан үзүүлэлттэй байна.

| Огноо       | Усны зарцуулалт (м3) | Усны төлбөр (төгрөг) | Дулааны зарцуулалт (Гдж) | Дулааны төлбөр (төгрөг) | Цахилгааны зарцуулалт (кВт.цаг) | Цахилгааны төлбөр (төгрөг) | Шатахууны зарцуулалт (литр) | Шатахууны төлбөр (төгрөг) |
|-------------|----------------------|----------------------|--------------------------|-------------------------|---------------------------------|----------------------------|-----------------------------|---------------------------|
| 2020        | 8,639                | 22,287,787           | 12,545                   | 91,286,472              | 2,844,057                       | 458,908,544                | 267,121                     | 615,982,377               |
| 2021        | 6,746                | 17,405,252           | 12,091                   | 87,983,151              | 2,183,502                       | 263,180,263                | 64,679                      | 176,769,153               |
| 2022        | 9,829                | 38,040,036           | 12,175                   | 88,594,273              | 2,972,547                       | 530,908,102                | 103,508                     | 398,507,511               |
| 2023        | 19,647               | 76,033,890           | 11,861                   | 121,524,251             | 3,010,248                       | 598,704,898                | 105,547                     | 406,356,644               |
| <b>Нийт</b> | <b>1,841,280</b>     | <b>1,450,714,429</b> | <b>797,218</b>           | <b>1,017,077,962</b>    | <b>883,327</b>                  | <b>1,403,319,551</b>       | <b>984,869</b>              | <b>1,737,816,350</b>      |

2023 оны хэрэглээний зардлын бүртгэлийн мэдээлэл. Дулааны зарцуулалт өнгөрсөн оныхтой ойролцоо боловч төлбөр өссөн байгаа нь нэгж өртөг улсаас нэмэгдсэнтэй холбоотой байна.

## ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Үндэсний тэргүүлэгч банк болохын хувьд ХААН Банк нь банк санхүүгийн салбартаа харилцагчийн үйлчилгээгээр манлайлагч байх өндөр үүрэг хариуцлага хүлээдэг. Бид цахим банкны шинэчлэл, өсөлт дэвшилтэд тулгуурлан салбар тооцооны төв, Үйлчилгээний нэгдсэн төв, цахим сувгуудаараа дамжуулан харилцагчийн үйлчилгээг улам сайжруулж, Монголдоо тэргүүлэх хэмжээний харилцагчийн туршлага төвтэй байгууллага болох зорилго тавин ажиллаж байна.

### Харилцагчийн туршлагын бодлого, Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого

Бид Монгол орны өнцөг булан бүрд байрлах салбар тооцооны төвүүд болон цахим сувгуудаараа дамжуулан харилцагчдаа санхүүгийн аяллын алхам бүрд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг “Харилцагчийн туршлагын бодлого” болон “Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого”-ын зургаан зарчмыг мөрдлөг болгон ажиллахын сацуу харилцагчдаа амлалт өгч ажилладаг. Харилцагчийн туршлагын бодлого болон уг бодлогын Банкны эрх, үүрэг, Харилцагчийн эрх, үүргийг харилцагчдаа нээлттэй мэдээлэх үүргийн дагуу ХААН Банкны вэбсайтад нээлттэй байршуулсан.

Харилцагчийн туршлагын бодлого болон уг бодлогын Банкны эрх, үүрэг, Харилцагчийн эрх, үүргийг харилцагчдаа нээлттэй мэдээлэх үүргийн дагуу ХААН Банкны вэбсайтад нээлттэй байршуулсан.

### Олон улсын нэгдсэн менежментийн тогтолцооны ISO9001:2015; ISO10002:2018 стандарт

ХААН Банк нь Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Чанарын менежмент, Байгууллагад гомдол шийдвэрлэх удирдамж ISO 10002:2018 олон улсын стандартуудыг нэвтрүүлсэн. Ингэснээр банкны хэмжээнд үйл ажиллагаандаа нэгдсэн цогц менежментийн тогтолцоог хэрэгжүүлж харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, олон улсын түвшинд нийцүүлэн ажиллаж байна. Түүнчлэн харилцагчдынхаа дуу хоолойг сонсож, санал хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэн харилцагчийн сэтгэл ханамжийг өндөр байлгахад тогтмол анхаарч, бүтээгдэхүүн үйлчилгээндээ хяналт тавьж ажилладаг.

### Олон улсын дижитал хэрэглэгчийн туршлагын стандарт 2022:02

ХААН Банк харилцагчдаа хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ жилээс жилд сайжруулан, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэх, түүний дотор цахим үйлчилгээний чанарт илүүтэй анхаарч ажилладаг билээ. Энэ үндсэн зорилтын хүрээнд ХААН Банк үйл ажиллагаандаа сүүлийн хагас жилийн хугацаанд Олон улсын хэрэглэгчийн туршлагын институтээс гаргасан “Олон улсын дижитал хэрэглэгчийн туршлагын стандарт” (IDCXS2022:02)-ын 7 бүлэг, 356 дэд шалгуурыг бүрэн хангаж 91 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлснийг Их Британийн стандартын институт (BSI) батламжиллаа. Энэ нь ХААН Банкны цахим үйлчилгээ, хэдийнээ олон улсын түвшинд хүрснийг илтгэн харуулж байна.

### Санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой оролцогч талуудын эрх, үүрэг

Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор банк болон харилцагчийн эрх, үүрэгтэй ЭНД дарж танилцана уу.

### Чанарын удирдлагын тогтолцоо

2023 онд 1.19 тэрбум санхүүгийн гүйлгээний 94 хувь нь цахим сувгаар, 5 хувь нь АТМ-аар хийгдсэн бол 1 хувь нь салбарт хандан ажилтнаар дамжин хийгдсэн байна. Бид харилцагчаас ирүүлсэн үйлчилгээний доголдлын талаарх санал, хүсэлтийг зургаан сувгаар 24 цагийн турш хүлээн авдаг бөгөөд 2023 онд нийт санхүүгийн гүйлгээний 0.015%-тай тэнцэхүйц хэмжээний санал, гомдол хүлээн авсан. Үүнээс 92 хувийг хяналтын хугацаанд, 29 хувийг анхны хандалтаар шийдвэрлэсэн байна.

2022 онтой харьцуулахад бүтээгдэхүүн үйлчилгээний доголдолтой холбоотой санал, гомдол 2023 онд 17 хувиар өссөн ба үүнээс цахим бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамааралтай нь хамгийн өндөр буюу 81 хувиар нэмэгдсэн байна.

Түүнчлэн харилцагчаас ирүүлж буй санал, гомдолд дүн шинжилгээ хийж, гомдлоос урьдчилан сэргийлэх, давтан гаргахгүй байхад онцгой анхаарал хандуулан холбогдох арга хэмжээг тасралтгүй авч, сайжруулж ажилласан.

### Сэтгэл ханамжийн судалгаа

Банк нь бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа тогтмол хэмждэг бөгөөд харилцагчийн сэтгэл ханамжийн үзүүлэлтүүдийг сайн хэвээр хадгалан ажиллалаа. NPS буюу ХААН Банкныг бусдад санал болгох түвшин +18 байна.



### Дүрэмт хувцас

ХААН Банкны брэнд шинэчлэл болон Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд дүрэмт хувцасны шинэчлэлийг хийсэн бөгөөд өнгө, материал, хийц, ажилтны эрүүл ахуйд тавигдах шаардлагыг нарийн тусгасан. Уг шинэчлэлтээр ажилтны эрүүл мэндэд аливаа сөрөг нөлөөгүй, биед тухтай, чөлөөтэй, ямар ч улиралд өмсөхөд тохиромжтой болгосон нь ажилтнуудын сэтгэл ханамж, ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлж байна.

## ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨРӨНГӨ ОРУУУЛАЛТ





## ХААН БАНК САНГИЙН ТУХАЙ

ХААН Банк нь анх 2007 онд компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк санг байгуулж, нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах төсөл, хөтөлбөрүүдээ системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн билээ. Улмаар 2018 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн зорилгыг үйл ажиллагаатайгаа нягт уялдуулан ажиллаж эхэлснээр өргөн хүрээг хамарсан тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтыг Монгол Улс даяар хэрэгжүүлж байна.

### ХААН Банкны эрхэм зорилго болон Тогтвортой хөгжлийн бодлого

ХААН Банкны харилцагчид

ХААН Банкны үйл ажиллагаа явуулж  
буй газар нутаг

Олон нийт, ард иргэд

ХААН Банкны ажилтнууд  
болон тэдний гэр бүл

ХААН Банк сангаас нийгмийн сайн сайханд бодитой хувь нэмрээ оруулахад чиглэсэн дараах тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.



Хүүхэд залуусын боловсролыг дэмжих



Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах



Байгаль орчноо хамгаалах



Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих



Соёл урлагийг дэмжих



Орон нутгийн хөгжлийг дэмжих



Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулах



ХААН Банк сангийн хувьд өнгөрсөн 17 жилийн хугацаанд нийт 510 гаруй төсөл, хөтөлбөрийн үр шимийг Монгол орны өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч, сурч, хөдөлмөрлөж буй 2.9 сая харилцагч, тэдний гэр бүлд бодитоор хүргэж, амьдралд нь эерэг өөрчлөлт, хандлагыг бий болгосон байна. Үүний зэрэгцээ төрийн болон төрийн бус 170 гаруй байгууллагатай хамтран, нийгмийн сайн сайхны төлөө 12,7 тэрбум гаруй төгрөг зарцуулсан бөгөөд 2023 оны хувьд нийт 9 төсөл, хөтөлбөрийг 2.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүллээ. Энэ хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг онцлон хүргэж байна.

## БОЛОВСРОЛ

### “RISE шинэ оюутны хөгжлийн хөтөлбөр”

Хэрэгжиж буй хугацаа: 6 жил

2023 онд хамрагдсан оюутны тоо: 800 гаруй

Нийт хамрагдсан оюутны тоо: 4,300

Уриа үг: “Суралцъя, хөгжье”

**Хөтөлбөрийн зорилго:** Шинэ оюутнуудыг их сургуулийн орчинд хурдан дасан зохицох, хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх, амжилттай суралцах арга барил эзэмших, цаашлаад их хотын соёлтой, зөв төлөвшилтэй иргэн болоход чиглүүлэн дэмжих, бие даасан оюутан болоход туслах юм.

Хөтөлбөрийн хүрээнд сонирхолтой арга хэмжээ, сургалтыг хичээлийн жилийн турш зохион байгуулдаг төдийгүй энэ бүгдээс хамгийн оргил үе буюу оюутнуудад мартагдашгүй дурсамж үлдээн, сэтгэл догдлуулдаг үйл явдал нь “RISE” хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ юм. Энэ оны хувьд нээлтийн арга хэмжээний нэг онцлог нь оюутан залуусыг Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмэр оруулахад уриалан, энэ талаар ойлголт өгч, хэрхэн байгальд ээлтэй иргэн байх тухай мэдлэг мэдээллийг нээлтийн арга хэмжээний үеэр өгсөн юм.

“Эм Ай Юу” их сургуулийн оюутан М.Буян-Эрдэнэ: Шинэ оюутнуудад мэдэхгүй олон зүйл байдаг. Хэрхэн зөв системээр зөв суралцах, ирээдүйд тохиолдох боломжуудыг хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгсөн өгөөжтэй сургалт боллоо.

Нэгэн хэвийн сургалт биш маш сонирхолтой мэдээллүүдийг авч чадлаа. Дахиад олон үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй байна.



### “Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр”

Хэрэгжиж буй хугацаа: 3 жил

2023 онд хамрагдсан оролцогчдын тоо: 120 багш

Нийт хамрагдсан оролцогчдын тоо: 360

**Хөтөлбөрийн зорилго:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, хувь хүн болон мэргэжлийн хувьд өсөж дэвшихэд нь туслах, албан тушаал, ажил үүрэг, мэргэжлийн онцлог, давуу талыг нийгэмд таниулах, эерэг хандлага бий болгох.

Эмэгтэй багш нарт ажлын байран дээрээ манлайлах, өсөж дэвших, хувийн хөгжилдөө анхаарах боломжийг бүрдүүлэх үүднээс:

- Хувь хүний хөгжил
- Гоо зүй
- Эрүүл мэнд
- Санхүүгийн боловсрол
- Сэтгэл зүй
- Англи хэл гэсэн 6 төрлийн хичээлээс 4-ийг нь сонгон суралцсан юм.

Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрт хүн амын эрүүл мэндийн төлөө энхийн манаанд ажилладаг нийт 240 сувилагч, асрагчийг чадавхжуулсан бол 2023 онд хүүхэд багачуудад ерөнхий эрдмийн мэдлэг, суурь боловсрол олгодог дунд сургуулийн эмэгтэй багш нарын дунд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээрээ онцлог болсон юм.



**Байгаль-Эх лицей сургуулийн математикийн багш Б.Ариунзул:** Энэ бол зөвхөн 120 шилдэг оролцогч нарт зориулсан хөтөлбөр биш. Нэг багшийн цаана 5 ангид суралцаж буй хүүхдүүд гэж бодоход л 600 гаруй хүүхдэд шууд хүрсэн Монгол орон даяар хамарсан ийм сайхан хөтөлбөрт хамрагдсандаа маш их баяртай байна. Бид бүхэнд энэхүү боломжийг олгосон ХААН Банкны хамт олонд баярласан талархсанаа илэрхийлье.

**“Аксиом Инк” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Нарантунгалаг:** ХААН Банк сангийн хамт олонд Монгол Улсын хамгийн чухал салбар болох боловсролын салбарыг сонгож, олон багш нар, эмэгтэйчүүдийг дэмжиж ажилласан явдалд талархаж буйгаа илэрхийлье. Боловсролд хөрөнгө оруулалт хийнэ гэдэг хамгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт байдаг.

## “ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр”

Хэрэгжиж буй хугацаа: 17 жил

2023 онд хамрагдсан оролцогчдын тоо: 59

Нийт хамрагдсан оролцогчдын тоо: 2,159

**Хөтөлбөрийн зорилго:** Амьдралынхаа шинэ хуудсыг эхлүүлэх гэж буй ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн шилдэг сурагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх

2023 оны хувьд уламжлал ёсоор Монгол Улсын 21 аймаг, Замын-Үүд, Зүүнхараа сум болон Улаанбаатар хотын Багануур дүүргийн сурагчдын дунд тэтгэлэг зарласан бөгөөд сурагчдын дүнгийн жагсаалт, анги удирдсан багшийн тодорхойлолт, нийгмийн идэвх оролцоо, уралдаан тэмцээн, олимпиадад оролцсон байдал болон “Би ирээдүйгээ төсөөлөхдөө...” сэдвээр бичсэн эссе бичигт үндэслэн тэтгэлгийн эздийг шалгарууллаа. Зөвхөн ХААН Банк сан өнгөрсөн хугацаанд 2.2 тэрбум гаруй төгрөгийн оюуны хөрөнгө оруулалт хийсэн бол үүнээс гадна ХААН Банк ажилтнуудынхаа хүүхдүүдэд мөн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгодог билээ.

**МУИС-ийн I курсийн оюутан Ж.Даваажаргал:** “Би Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас шалгарч энэхүү тэтгэлэгт хамрагдсан. Тэтгэлэгт материал бүрдүүлэх үе шатнаас эхлээд л өөрөө өөртэйгөө тулж ажиллах шаардлага тулгарсан учраас маш их хичээсэн. Бас өөрийнхөө тухай эссе бичих хамгийн хэцүү байсан. Гэхдээ эссендээ хий хоосон мөрөөдөл бүс яг л өөрийнхөө зорьж, зүтгэж байгаа зорилгоо тодорхой бичсэн”



**СЭЗИС-ийн I курсийн оюутан Б.Номин:** “Би Баянхонгор аймгаас энэхүү тэтгэлэгт шалгарсан. Хичээл сургуульдаа шамдахаас гадна сагсан бөмбөгийн спортоор хичээллэдэг. Одоо Дээд лигийн “Улаанбаатар Амазонс” багт тоглодог. Мэргэжлийн тамирчны бэлтгэлийн хуваарийн хажуугаар хичээл сургуулиа тэнцвэртэй авч явахын тулд цагийн хуваариа маш сайн төлөвлөхийг хичээдэг. Ингэж өөрийгөө бүрэн дайчилж, аль алинд нь амжилт гаргаж байгаа нь энэхүү тэтгэлэгт хамрагдахад хамгийн их түлхэц болсон гэж бодож байна”



## ЭРҮҮЛ МЭНД

### “Хавдрын эсрэг үндэсний аян”

**Хөтөлбөрийн зорилго:** Олон нийтэд хорт хавдраас сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрсдэлт бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах, эрт үед нь оношилж, эмчлэх, хорт хавдрын эрт илрүүлэг, хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

**Хэрэгжиж буй хугацаа:** 13 жил

**2023 онд аян хэрэгжсэн аймаг:** Дорнод, Увс

**2023 онд үзлэгийн тоо:** 3,052

**Нийт үзлэгийн тоо:** 133,000 гаруй

**Аяны үр дүн:**

- Эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалт - 149
- Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэний сургалт -30
- Хортой хавдар - 26
- Хоргүй хавдар -305
- Хавдар сэжиглэгдсэн - 62
- Мэс ажилбар - 14
- Эд, эсийн шинжилгээ - 312
- Хавдрын урьдал - 156
- Бусад өвчлөл 1,568 тохиолдол тус тус илрүүлэн ажилласан байна.



**Дорнод аймгийн иргэн:** В, С вирустэй тул Улаанбаатар хот явж төв эмнэлэгт оношлуул гэж багийн эмч хэлсэн боловч явч чадахгүй байсан. Харин нарийн мэргэжлийн эмч нар манай аймагт ирж үзлэг хийж байгаад маш их баяртай байна.

**Дорнод аймгийн иргэн:** Аяны хүрээнд ирсэн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх завшаан тохиож байгаад баяртай байна. Эмч нарыг авчирч, ард иргэдэд илүү ойр хүрч ажиллаж байгаад ХААН Банканд баярлалаа гэж хэлмээр байна.

### “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”

**Хөтөлбөрийн зорилго:** Хүн амын нас баралтын гол шалтгаан болж буй зүрх судасны өвчнийг эрт оношлох, иргэдэд амьдралын зөв хэв маяг, цаашдын эерэг нөлөөг сурталчлан таниулах, эмнэлгийн тусламж авч чадахгүй байгаа зорилтот бүлгийн иргэдийг цусны даралт ихсэх өвчний үзлэг оношилгоонд хамруулах

**Хэрэгжиж буй хугацаа:** 7 жил

**2023 онд аян хэрэгжсэн аймаг:** Дундговь, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Дархан-Уул

**2023 онд үзлэгийн тоо:** 22,300

**Нийт үзлэгийн тоо:** 41,300 гаруй

Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийн төрлүүд:

- Зүрх судас
- Зүрхний шигдээс
- Мэдрэл
- Тархины цус харвалт
- Бөөр
- Хоол боловсруулах замын эмгэг

2023 онд 300 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн сайн дурын 173 ажилтныг бэлтгэн ажиллалаа. Ийнхүү 2017 оноос эхлүүлсэн тус аянд нийт 17 аймгийн 41,300 гаруй иргэн, 900 гаруй эмч хамрагдлаа.



## БАЙГАЛЬ ОРЧИН

### “ХААН Банкны ой хөтөлбөр”

**Хөтөлбөрийн зорилго:** Амьдралыг тэтгэгч байгалиа хамгаалж, цэвэр агаар, эрүүл, ногоон орчныг хойч үедээ өвлүүлэхэд хувь нэмрээ оруулах

**Хэрэгжиж буй хугацаа:** 3 жил

**2023 онд тарьсан модны тоо:** 13,903

**Нийт тарьсан модны тоо:** 44,900

Хүний буруутай үйл ажиллагаа, байгалийн хортон шавьжид өртөн, ургах чадвараа алдаж, ойгүй болсон 40 га талбайг ойжуулах ажлын бэлтгэлийг ХААН Банк сангаас Сэлбэ голын эх, Их Баяны аманд 2021 оноос эхлүүлсэн билээ. Энэ хүрээнд 2023 онд 10 га талбайд ойжуулалт хийсэн бөгөөд нийт тус байршилд 24 га талбайд мод тарьж ойжуулаад байна. Сэлбэ голын эх, Их Баяны амыг ойжуулах 5 жилийн хугацаатай уг төслийн хүрээнд Нийслэлийн байгаль орчны газар болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ойг арчилж, нөхөн сэргээлт хийж, хяналт тавин ажиллаж байгаа юм. Үүнээс гадна ХААН Банк нь орон даяар байгаа салбаруудаараа дамжуулж Монгол Улсын өнцөг булан бүрд мод тарьдаг билээ.





### Тэрбум мод сан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн хувь нэмрээ оруулах амлалтууд өгснөөс Монголын арилжааны банкууд 50 сая мод тарихаар энэхүү санаачилгад нэгдсэн юм. Үг амлалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк, Монголын банкны холбооноос “Тэрбум мод” санг 2022 оны 3-р сард үүсгэн байгуулж, банкууд үйлчилгээний шимтгэлийн тодорхой дүнг “Тэрбум мод” санд санхүүжилт болгон олгодог болсон билээ. Энэ сангаар дамжуулан Монголын арилжааны банкууд нийт 37 га талбайд, 105,000 гаруй мод тариад байна.



## СОЁЛ УРЛАГ

### ХААН галерей

ХААН Банк нь соёл урлагийг дэмжих хүрээнд ХААН Банк цамхгийн 3-р давхарт байрлах ХААН галерейд сар бүр уран бүтээлчдийн үзэсгэлэнг үнэ төлбөргүй зохион байгуулдаг билээ. Үзэсгэлэн гаргах хүсэлтэй уран бүтээлчдийн сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэйгээр зарладаг бөгөөд 2023 оны туршид шалгарсан уран бүтээлчдийн нийт 11 үзэсгэлэнг олон нийтэд дэлгэн танилцууллаа. Үүнд:



Б.Өлзийхишиг  
"Artu"



Э.Билигт  
"Хүн дүүрэн тал"



О.Үржинханд  
"Emotional Quotient"



Р.Гал-Од  
"Шог зургийн ертөнц"



Г.Мөнхболор  
"Works"



С.Саранцацралт, Д.Отгонбаяр,  
Ц.Солонго, Э.Ононгуа  
"S.O S.O"



Д.Отгонбаяр  
"Нууцаас нууцад..."



Ц.Цэгмэд  
"Тэнгэрийн дуудлага"



Ну Жонсук  
"Shadow of the blank 5"



Франц, Испани, Маритоус,  
Австри, Португал, Монголын  
уран бүтээлчид  
"Concept of WE"



ХБНГУ-ын Элчин сайдын яам, Норд  
Арт олон улсын үзэсгэлэнгийн  
төслөөр анхдугаар  
"Mongolian Art- sculpture symposium"

### Нийгмийн хариуцлагын төслийн уралдаан

**Төслийн зорилго:** ХААН Банкны ажилтнуудыг идэвхжүүлэх, нийгмийн сайн сайхныг бүтээлцэхэд дэмжлэг үзүүлэх шинэ санал, санаачилга бүхий шинэ төслийг шалгаруулах;

Уралдаанд нийт 50 төсөл ирүүлснийг 2 удаагийн сонгон шалгаруулалтаар шалгаруулж, тэргүүн, дэд байр болон тусгай байр шалгаруулан шагнал гардуулав. Үүнд:

- **1-р байр** - “Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын боловсролыг дэмжих, тэгш бус байдлыг бууруулах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэн дэмжих хөтөлбөр”
- **2-р байр** - “Инээмсэглэл” хүүхдийн шүдний эрүүл мэндийн төсөл
- **Тусгай байр** - “Сэтгэл эдгэрдэг” сэтгэл зүйн эрүүл мэнд, сэтгэл зүйн нөлөөллийн аян хэрэгжүүлэх төсөл

Ажилтнуудын дунд анх удаа зохион байгуулсан тус уралдаанд урт хугацааны чөлөө, хүүхэд асрах чөлөөтэй гэх мэт бүхий л ажилтнууд оролцох боломжтой байсан бөгөөд ажилтнуудын оролцоо өндөр, санал санаачилга дүүрэн уралдаан болж өндөрлөсөн юм.



## ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

### “3х3 сагсан бөмбөгийн талбай”

**Хөтөлбөрийн зорилго:** Хүүхэд залуусын эрүүл мэнд, хүсэл мөрөөдлийг дэмжин, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бий болгох

**Хэрэгжиж буй хугацаа:** 3 жил

ХААН Банк 2021 онд түүхт 30 жилийн ойгоо тохиолдуулан компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 33 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг амжилттай зохион байгуулсан билээ. Үг сагсан бөмбөгийн талбай нь олон улсын стандартад нийцсэн резинэн

зөөлөвчтэй шал, материал, тоноглолоор хийгдсэн, тэнд тоглох хүүхэд, залуусын эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгой анхаарч, мэргэжлийн байгууллагуудтай энэ тал дээр хамтран ажилласнаараа онцлог. ХААН Банк дан ганц бүтээн байгуулалт хийгээд орхилгүй арчлалт хамгаалалтад нь анхаарч, тухайн орон нутгийн засаг захиргаа болон Биеийн тамир спортын хороо, ерөнхий боловсролын сургуулиудад талбайг хүлээлгэн өгсөн юм. Мөн 2022 онд 21 аймагт сагсан бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан бол 2023 онд 16 байршилд 3500 гаруй тамирчныг хамруулан сагсан бөмбөгийн нөхөрсөг тэмцээн дахин зохион байгуулж, залуусын спортын идэвх, оролцоог дэмжлээ.



## НИЙГМИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙГ ДЭМЖИХ

### Парабочи спорт

**Хөтөлбөрийн зорилго:** Парабочи спортоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хичээллүүлэх, дотоодын болон олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, спортоор дамжуулан нийгэмд эрх тэгш хөгжих боломжийг олгох

**Хэрэгжиж буй хугацаа:** 5 жил

ХААН Банк нийгмийн зорилтот бүлгийг дэмжих хүрээнд 2019 оноос Монголын парабочигийн холбоотой хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд парабочи спортын төрлөөр сургалт зохион байгуулан, дотоодын болон олон улсын тэмцээн, уралдаанд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

2023 оны хувьд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, Польш улсын Познань хотод зохион байгуулагдсан “Дэлхийн парабочигийн цуврал тэмцээн 2023”-т тамирчид оролцуулахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Энэ оны хувьд Монгол Улсын тамирчид тус спортоор анх удаа шигшээ 8-т шалгарсан нь онцлог байв.



A photograph of a modern glass skyscraper, likely a corporate headquarters, partially obscured by lush green trees. The building's glass facade reflects the surrounding greenery and sky. The text is overlaid on the lower left portion of the image.

# ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТАЙЛАГНАЛ



## ДОТООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Олон нийтэд нээлттэй хариуцлагатай хувьцаат компани болсны хүрээнд Тогтвортой хөгжил, БОНЗ-ын тайлан, мэдээ мэдээлийг олон улсын болон дотоодын санхүүгийн байгууллагуудын стандарт шаардлагын дагуу хүргүүлэн ажилласаар байна. Бид хамтын ажиллагааны хүрээнд дараах олон улсын болон дотоодын байгууллагуудад идэвхтэй гишүүнчлэлтэй, ил тод тайлагналтай хамтран ажиллаж байна.



## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



ХААН Банк харилцагчдынхаа урт хугацаат санхүүжилтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох, банкны тогтвортой эх үүсвэрийн төрлийг нэмэгдүүлэх, банкны үйл ажиллагааг тогтвортой байлгах үүднээс олон улсын стандарт, сайн жишигт нийцүүлэх, тогтмол сайжруулах зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангуудтай урт хугацаат түншлэлийн харилцааг бий болгон ажилласаар ирсэн.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар олон улсын банк, санхүүгийн байгууллагаас татсан урт хугацаат, тогтвортой санхүүжилтийн хэмжээ 568 сая ам.долларт хүрсэн байна.

Түүнчлэн, гадаад худалдаа эрхлэгч ААН-үүдийн гадаад худалдааны тогтвортой үйл ажиллагааг дэмжих, тэдний үйл ажиллагааны онцлог, гадаад худалдаатай холбоотой эрсдэлийг бууруулан удирдахад зориулан олон улсад өргөнөөр ашиглагддаг худалдааны төлбөр тооцооны хэрэгсэл, санхүүжилтийн үйлчилгээг Олон улсын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргасан UCP, URDG, ISP, Incoterms зэрэг нийтлэг стандартын дагуу санал болгон ажиллаж байна. Энэ хүрээнд олон улсын 20 гаруй банк, санхүүгийн байгууллагаас 200 гаруй сая ам.долларын худалдааны шугам нээлгэн, харилцагчдынхаа гадаад худалдааг санхүүжүүлэхээс гадна харилцагчдын гадаад төлбөр тооцоог найдвартай, хурдан шуурхай гүйцэтгэх зорилгоор 14 улсын, 28 банканд 13 төрлийн валютаар 49 гадаад ностро данс нээн, харилцааг амжилттай хадгалан ажиллаж байна.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-тай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, банкны бүх түвшний үйл ажиллагаанд хүүхдийн эрхийг дээдэлж, хамгаалж ажилласаар байна. Санамж бичигт гарын үсэг зурснаар НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд”, “Гэр бүл, хүүхдэд ээлтэй бодлого”-ыг ХААН Банк бизнесийн үйл ажиллагаандаа уялдуулж, гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогыг сурталчлах, ажилтнуудынхаа гэр бүл, хүүхдийн хөгжилд илүү анхаарах, мөн хүүхдийн эрхийн талаар мэдлэг боловсрол олгох зэрэг олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж байна.

ХААН Банк Partnership for Carbon Accounting Financials (PCAF) буюу санхүүгийн салбарт хүлэмжийн хийг хэмжих хамтын ажиллагааны санаачилгад нэгдэж, гишүүн байгууллагуудтай түнш хамтын ажиллагаа тогтоох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах чухал алхмыг эхлүүлээд байна.

Түүнчлэн ХААН Банк олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдаас жөндөрийн болон ногоон санхүүжилтийн эх үүсвэр татаж, харилцагчдадаа бүх төрлийн ногоон зээл санал болгож буйгаас гадна Монгол Улсаас анх удаа олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээл дээр Ногоон бонд гаргаад байна.



## ИЛ ТОД БАЙДАЛ БА ТАЙЛАГНАЛ

ХААН Банк нь Банкны тухай хууль болон зохицуулагч байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм журам, шаардлагуудыг бүрэн хангаж ажилласан ба үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, мэдээллээ тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Үүнээс гадна, зээлдүүлэгч олон улсын банк санхүүгийн байгууллагууд, корреспондент харилцаатай банкууд, олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоогч байгууллагуудаас тавигдаж буй санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна үйл ажиллагаанд тавигдах байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудаа олон улсын стандарт, шаардлагуудад нийцүүлэн ажиллах санхүүгийн бус үүрэг хүлээдэг. Энэ хүрээнд нээлттэй, ил тод тайлагналыг хөрөнгө оруулагчдад тогтмол давтамжтайгаар гаргаж хүргүүлдэг. Мөн тухайлсан зориулалтаар авсан санхүүжилтийн хувьд эх үүсвэрийн ашиглалт, санхүүжилтийн үр нөлөөг харуулсан тайлан мэдээг зээлдүүлэгч байгууллагууддаа улирал бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Тайлант хугацаанд олон нийтэд ил тод тайлагналтай байж, оролцогч талуудаа үнэн зөв мэдээллээр ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Банкны Тогтвортой хөгжлийн бодлого болон компанийн нийгмийн хариуцлагын стратегийн хүрээнд хэрэгжүүлсэн санал санаачилга болон төсөл, хөтөлбөрүүдийн тухай мэдээлэлтэй “Тогтвортой хөгжлийн тайлан”-г зургаа дахь жилдээ бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

НҮБ-ын дэргэдэх “Даян дэлхийн гэрээ”-нд 2018 оноос ХААН Банк идэвхтэй тайлагналыг хүргүүлэн ажиллахын зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ хэрхэн оруулж буй үйл ажиллагааны тайлангаа хүргүүлж, асуулгуудад мэдээллийг хүргүүлээд байна.

Тогтвортой хөгжлийн чиглэлээр Монголбанк, Монголын Тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС) зэрэгтэй ногоон зээл, хариуцлагатай санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний хэрэгжилтийн тайлан, мэдээг хүргүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамтран ажиллалаа.

Монголын хөрөнгийн биржийн Байгаль орчин нийгэм засаглалын үйл ажиллагааны тайланг бэлтгэн олон нийтэд хүргүүлээд байна.

Гаднын хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудад банкны зүгээс тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилт, Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлан (Environment, Social and Governance/ ESG/ report) болон энэ төрлийн бусад холбогдох тайлан, мэдээг хүргэлээ.



ХААН Банк Ногоон бонд гаргахдаа Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны гаргасан Ногоон бондын зарчим болон Монгол Улсын ногоон таксаномид нийцүүлэн өөрийн “Ногоон бондын санхүүжилтийн хүрээ”-г боловсруулсан бөгөөд үүний дагуу бондын санхүүжилтийн үйл ажиллагаа, үр нөлөөллийн тайланг зохицуулах байгууллага, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй. Энэ хүрээнд банк мэдээллээ өөрийн албан ёсны вэб хуудас болон хөрөнгө оруулагчдын тайлагналын платформд оруулж мэдээлэх юм.

2023 онд ХААН Банк нь олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд нийт 200 гаруй тайланг олон улсын эзэлдүүлэгч, хөрөнгө оруулагч болон эзэлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоогч байгууллагуудад хүргэж ажилласан байна.

**ХАВСРАЛТ**

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2023

| Бүлэг                                                                  |                                       | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                            |                                                                                                                              | Үзүүлэлт<br>(өмнөх он) | Үзүүлэлт<br>(тайлант он) | Хэмжих нэгж                                                                                                                                                                                                                                                                      | Нэмэлт мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Тайлбар         | Холбоос            |
|------------------------------------------------------------------------|---------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|--------------------|
| Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд |                                       |                                                                                                                                                                                                             |                                                                                                                              |                        |                          |                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                 |                    |
| MS1.1                                                                  | Тогтвортой хөгжлийн удирдлагын систем | Удирдлагын амлалт                                                                                                                                                                                           | Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх                                                         | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | "ХААН Банк 2010 онд НҮБ-ын дэргэдэх Даян дэлхийн гэрээний 4 бүлэгт 10 зарчмыг дагаж мөрдөх амлалтаа илэрхийлсэн байдаг. Түүнчлэн 2013 онд ТоС-ын 8 зарчмыг хэрэгжүүлэхээ илэрхийлсэн.Эдгээрийг хэрэгжүүлэх болон Монгол Улсын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зургийн хүрээнд 2023 онд 5%-ийг 2025 он гэхэд банкныхаа нийт зээлийн багцын 10%-ийг ногоон зээлийн багцаар бүрдүүлэхээр зорин ажиллаж байна." |                 | GRI 102            |
| MS2.1                                                                  |                                       | Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт                                                                                                                                                                    | Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх                                                            | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | <a href="https://www.khanbank.com/personal/about/sustainable-development-policy/">https://www.khanbank.com/personal/about/sustainable-development-policy/</a>                                                                                                                                                                                                                                                    |                 | GRI 103, ISO 14001 |
| MS2.2                                                                  |                                       | Бүтэц удирдлага                                                                                                                                                                                             | Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх                                                        | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | 2023 онд Тогтвортой хөгжлийн хороог Гүйцэтгэх захирлын тушаалаар 13 гишүүн, 5 байнгын оролцогчидтойгоор байгуулаад байна.                                                                                                                                                                                                                                                                                        |                 | GRI 103, ISO 14001 |
| MS3.1                                                                  |                                       |                                                                                                                                                                                                             | ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх                      | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | "Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг ба тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг."                                                                                                                                                                                                                |                 | GRI 102            |
| MS3.1                                                                  |                                       |                                                                                                                                                                                                             | ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх                      | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | "Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг ба тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг."                                                                                                                                                                                                                |                 | GRI 102            |
| MS3.2                                                                  |                                       |                                                                                                                                                                                                             | Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | "ХААН Банкны Гүйцэтгэх захирал банкны Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажилладаг буюу Тогтвортой хөгжлийн газрыг шууд удирдлагаар хангах, Тогтвортой хөгжлийн хороог даргалдаг."                                                                                                                                                                                                                            |                 | GRI 102            |
| MS3.3                                                                  |                                       |                                                                                                                                                                                                             | Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх      | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | ХААН Банкны Тогтвортой хөгжлийн газар нь үйл ажиллагааны түвшинд хариуцан ажилладаг                                                                                                                                                                                                                                                                                                                              |                 | GRI 102            |
| MS3.4                                                                  |                                       |                                                                                                                                                                                                             | Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?                                 | Тийм                   | Тийм                     |                                                                                                                                                                                                                                                                                  | "Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг. Тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг ба ТУЗ-ийн хурлаар тухай бүр асуудлыг хэлэлцдэг."                                                                                                                                                                  |                 | GRI 102            |
| MS3.5                                                                  | Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ | Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх | Тийм                                                                                                                         | Тийм                   |                          | 2022 онд ХААН Банк ОУ-ын үнэлгээний байгууллагаар БОНЗ-ын үнэлгээ хийлгэсэн ба үр дүнд үндэслэн 2023 оны 1-р сард оролцогч талуудын оролцоог хангасан нөлөөллийн болон чухал байдлын матрицтай болсон. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн 2023 оны тайлангаас үзнэ үү. |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | SASB            |                    |
| MS4.1                                                                  | Чадавх бүрдүүлэлт                     | Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр                                                                                                                          | 10                                                                                                                           | 41                     | минут                    | Тогтвортой хөгжлийн талаарх цахим сургалтад зарцуулах хугацаа: 41 минут байна харин танхим сургалтад зарцуулах хугацаа: 4 цаг байна.                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | GRI 102         |                    |
| MS4.2                                                                  | Хяналт                                | Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?                                                                                                       | Тийм                                                                                                                         | Тийм                   |                          | Тогтвортой хөгжлийн тайлангийн Дотоод аудит ба дотоод хяналтын хэсгээс үзнэ үү.                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | GRI 102, SDG 12 |                    |

| Бүлэг                                                                  |                                       | Шалгуур үзүүлэлт             |                                                                                                                                             | Үзүүлэлт<br>(өмнөх он) | Үзүүлэлт<br>(тайлант он) | Хэмжих нэгж                 | Нэмэлт мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                    | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Холбоос         |
|------------------------------------------------------------------------|---------------------------------------|------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд |                                       |                              |                                                                                                                                             |                        |                          |                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                 |
| MS4.3                                                                  | Тогтвортой хөгжлийн удирдлагын систем | Тогтвортой байдлын тайлагнал | Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу? | Тийм                   | Тийм                     |                             | <a href="https://www.khanbank.com/personal/about/sustainability-report/">https://www.khanbank.com/personal/about/sustainability-report/</a>                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | GRI 102, SDG 12 |
| S4.2                                                                   |                    | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд                             | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь                                                      | 1.6                    | 2                        | %           | "2021 оноос Монголын хараагүйчүүдийн төвийн харьяа хөгжлийн бэрхшээлтэй бариач нарыг ажиллуулж, ажилтнуудад барианы үйлчилгээ үзүүлдэг болсон ба 2022 оноос худалдан авах гэрээгээр тус үйлчилгээг авч гэрээний төрөл өөрчлөгдсөн."                                                                                                                                                      |         | SDG 10               |
| S4.3                                                                   |                    | Оффисын хүртээмж                                           | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу                                   | Тийм                   | Тийм                     |             | "Монгол Улсын Барилгын тухай хууль, Барилгын норм ба дүрмийн дагуу банкны эзэмшлийн бүх барилгууд налуу замтай хийгдсэн байдаг. Төв оффисын хувьд ОУ-ын оффисын А зэрэглэлийг хангасан стандарттай учир налуу зам, тэргэнцэртэй иргэн орж гарахад зориулсан хаалга, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусдаа ариун цэврийн өрөө гэх мэт ерөнхий шаардлагууд бүгд хангагдсан байдаг." |         | SDG 10               |
| S4.4                                                                   |                    | Торгууль                                                   | Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо                             | -                      | -                        | Төгсөг      | Зөрчил байхгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |         | SDG 10               |
| S3.5                                                                   | Хүртээмжтэй байдал | Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа                          | Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                                        | 78/22                  | 78/22                    | %           | ТУЗ-ийн гишүүдийн 78% нь эрэгтэй, 22% нь эмэгтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                  |         | GRI 405, SDG 5       |
| S3.6                                                                   |                    | Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа                       | Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                           | "62/38"                | 64/36                    | %           | "Гүйцэтгэх удирдлагын 64% нь эрэгтэй, 36% нь эмэгтэй байна."                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | GRI 405, SDG 5       |
| S3.7                                                                   |                    | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                         | 32/68                  | 32/68                    | %           | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын 32% нь эрэгтэй, 68% нь эмэгтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                         |         | GRI 405, SDG 5       |
| S3.8                                                                   |                    | Жендэрт суурилсан цалингийн зөрүү                          | Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа                                                             | 31/35                  | 22/32                    | харьцаа     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |         | GRI 405, SDG 5, SFRD |

| Бүлэг                                                                  |                                        | Шалгуур үзүүлэлт                                                 |                                                                                                                                                                                                             | Үзүүлэлт<br>(өмнөх он) | Үзүүлэлт<br>(тайлант он) | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Тайлбар | Холбоос                   |
|------------------------------------------------------------------------|----------------------------------------|------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|-------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------------------------|
| Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд |                                        |                                                                  |                                                                                                                                                                                                             |                        |                          |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         |                           |
| S5.1                                                                   | Нийгмийн хариуцлага ба ил тод байдал   | Оролцогч талуудын оролцооны засаглал                             | Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?                                                                                                                                     | Үгүй                   | Үгүй                     |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         | IFC                       |
| S5.2                                                                   |                                        | Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам    | Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)                                                                                                                 | Үгүй                   | Үгүй                     |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         | IFC Performance Standards |
| S5.3                                                                   |                                        | Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам                           | Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?                                                                                                                                                       | Тийм                   | Тийм                     |             | "ХААН Банк нь Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Чанарын менежмент-Байгууллагад гомдол шийдвэрлэх удирдамж ISO 10002:2018 олон улсын стандартыг нэвтрүүлсэн. Ингэснээр банкны хэмжээнд үйл ажиллагаандаа нэгдсэн цогц менежментийн тогтолцоог хэрэгжүүлж харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулж, олон улсын түвшинд нийцүүлэн ажиллах юм. Бид харилцагчийн гомдлыг шийдвэрлэхдээ “Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам”-г мөрдлөг болгон ажилладаг. Гомдол бүртгэх, хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны процессын талаар мэдээллийг ХААН БАНК-ны вэбсайтаас үзнэ үү.<br>/ <a href="https://www.khanbank.com/personal/news/servicePolicy/">https://www.khanbank.com/personal/news/servicePolicy/</a> " |         | GRI 102, SDG 16           |
| S5.4                                                                   |                                        | Олон нийтэд ил тод мэдээлэх                                      | Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?                                                                                      | Тийм                   | Тийм                     |             | “Бид “Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу харилцагчдаас гомдлыг дараах сувгуудаар хүлээн авч шийдвэрлэдэг.<br>1. Салбар, тооцооны төв<br>2. Үйлчилгэний нэгдсэн төв 18001917<br>3. Khanbank.com вэб сайт<br>4. Khanbank аппликэйшн<br>5. Khanbank сошиал сувгууд<br>6. Өргөдөл, маягтаар. "                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |         | IFC Performance Standards |
| S5.5                                                                   |                                        | Ажилчид/олон нийтийн санал гомдол                                | Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь                                                                                                                                             | 100                    | 92                       | %           | 2023 онд нийт хүлээн авсан гомдлын 92%-ийг хяналтын хугацаанд шийдвэрлэсэн. Бид ажилтнуудаасаа банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, процесс сайжруулахтай холбоотой саналыг дотоод саналын системээрээ дамжуулан өнгөрсөн онд нийт 394 саналыг хүлээн авч, холбогдох сайжруулалтуудыг хийж ажиллалаа.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         | GRI 413, SDG 8            |
| S5.6                                                                   |                                        | Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт | Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь                                                                                                           | 0.43                   | 0.48                     | %           | "ХААН Банк байгуулагдсан цагаас хойш Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төсөл хөтөлбрүүдийг хэрэгжүүлсээр байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн ...-р хуудаснаас үзнэ үү."                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |         | GRI 413, SDG 8            |
| S6.1                                                                   | Тогтвортой өртгийн сүлжээний менежмент | Худалдан авалтын бодлого, журам                                  | Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтэгсэн)? | Тийм                   | Тийм                     |             | "Худалдан авалтын бодлого, Худалдан авалтын журмыг дотооддоо мөрдөн ажилладаг. Тус журманд ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлогыг дагаж мөрдөж худалдан авалт хийх заалт тусгагдсан байдаг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн ...-р хуудаснаас үзнэ үү."                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | GRI 204, SDG 8            |
| S6.2                                                                   |                                        | Дотоодын худалдан авалт                                          | Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь                                                                                                                                                  | 87                     | 86                       | %           | Нийт 480 нийлүүлэгчээс худалдан авалт хийснээс 410 нь дотоодын харилцагч байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         | GRI 204, SDG 8            |
| S6.3                                                                   |                                        | Тогтвортой, ногоон худалдан авалт                                | Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь                                                                                   | 14                     | 15                       | %           | Ханган нийлүүлэгчийг сонгохдоо тогтвортой буюу нийгмийн хариуцлагын талаарх шалгуурын асуулгыг /гуравдагч талын асуулга дээр 2021.1 сараас нэмсэн/ авдаг бөгөөд тухайн шалгуурыг хангаж буй нийлүүлэгчийн эрсдэлийн түвшин бага гэж үнэлэгдэх мөн сонголтод нөлөөлдөг. /*62 нийлүүлэгч нь эрсдэлийн түвшин бага хэмээн үнэлэгдсэн байна/                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |         | GRI 204, SDG 8            |

| Бүлэг                                                                  |                      | Шалгуур үзүүлэлт                           |                                                                                                                                                                     | Үзүүлэлт<br>(өмнөх он) | Үзүүлэлт<br>(тайлант он) | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Тайлбар | Холбоос                                                    |
|------------------------------------------------------------------------|----------------------|--------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------------------------------------------------------------|
| Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд |                      |                                            |                                                                                                                                                                     |                        |                          |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         |                                                            |
| G1.1                                                                   | Авилгал болон ёс зүй | Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам | Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?                                                                                                                  | Тийм                   | Тийм                     |             | "ХААН Банкны Авлига, хээл хахуультай тэмцэх бодлогыг 2020 оны 2-р сарын 17-ны өдөр баталсан. Бодлогын баримт бичгийг олон улсын стандарт, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлан ажиллаж байна."                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | GRI 205, SDG 16                                            |
| G2.1                                                                   | Компанийн засаглал   | Удирдах зөвлөлийн хараат бус байдал        | Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь                                                                                                                   | 33                     | 33                       | %           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | "GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16" |
| G2.2                                                                   |                      | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх      | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?                                                                                             | Тийм                   | Тийм                     |             | <a href="https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf">https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf</a>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | "GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16" |
| G2.3                                                                   |                      | Компанийн засаглалын бодлого, журам        | Компанийн засаглалын бодлого, журам бий юу?                                                                                                                         | Тийм                   | Тийм                     |             | <a href="https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf">https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf</a>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |         | "GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16" |
| G3.1                                                                   | Комплайнс            | Комплаенсын бодлого                        | Комплаенсын бодлого, журам бий юу?                                                                                                                                  | Тийм                   | Тийм                     |             | "ХААН Банк нь МУТСТ олон улсын стандарт, зарчмуудыг дотоод бодлого журамдаа тодорхойлон тусгасан байдаг бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Бодлого, журамд жил бүр хяналт тавьж, хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журам, удирдамж шинэчлэгдэх тухай бүр нийцүүлэн, тогтмол шинэчлэх арга хэмжээг авдаг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү."                                                                                                                                                                                                                                                                                                     |         | "GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16" |
| G3.2                                                                   |                      | Комплаенсын хөтөлбөр                       | Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу? | Тийм                   | Тийм                     |             | "Банкны хэмжээнд дагаж мөрдөх Комплаенсын дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд 2023-2025 оны хөтөлбөрийг банкны Гүйцэтгэх удирдлагаас баталсан. Комплаенсын хөтөлбөрийн дагуу МУТСТ, Харилцагч таньж мэдэх, хориг арга хэмжээний хяналтын тогтолцоог тогтмол сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бий болгох зорилгоор бодлого журамд өөрчлөлт оруулахын зэрэгцээ, дижитал шилжилт, үйл ажиллагааг автоматжуулах, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг Банкны хэмжээнд хангуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Банкны ТҮЗ, Гүйцэтгэх удирдлага болон улмаар Монголбанканд тогтмол тайлагнан ажиллаж байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү." |         | "GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16" |

| Бүлэг                                                                                         |                      | Шалгуур үзүүлэлт            |                                                                                                                               | Үзүүлэлт<br>(өмнөх он) | Үзүүлэлт<br>(тайлант он) | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Тайлбар | Холбоос                                  |
|-----------------------------------------------------------------------------------------------|----------------------|-----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------------------------------------------|
| Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү) |                      |                             |                                                                                                                               |                        |                          |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |         |                                          |
| FS1                                                                                           | Санхүүгийн үйлчилгээ | Санхүүгийн хүртээмж         | Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр | 16,000                 | 75,440                   | хүн         | 2023 Тайлант оны хугацаанд Монгол орон даяар тархсан 540 гаруй салбар нэгжээрээ дамжуулан нийт 75,000 иргэд, хүүхэд залууст мэдээлэл хүргэн ажилласан.                                                                                                                                                                                                                                          |         | SDG 1                                    |
| FS2                                                                                           |                      | БОНЗ-ын эрсдэлийн менежмент | БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь                                  | 7.91                   | 9.5                      | %           | "БОНЗ-ийн эрсдлийн үнэлгээг Эдийн засгийн салбарын ангиллаар Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн түвшний ангиллаар өндөр дунд ангилагдсан бизнесийн зээлийн хүсэлтэд хийдэг. 2023 онд зээлийн дүнгээр 915.6тэрбум төгрөгийн 336 зээлийн хүсэлтэд БОНЗ-ийн эрсдлийн үнэлгээ хийгдсэн байна. Энэ нь зээлийн дүгнээр 2023.12.31-ний байдлаарх нийт зээлийн багцын үлдэгдлийн 9.5% ийг эзэлж байна." |         | Mongolian Sustainable Finance Principles |
| FS3                                                                                           |                      | Тогтвортой санхүүжилт       | Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксаномийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь                        | 1.049                  | 3.92                     | %           | "2023 оны төгсгөлд ХААН Банк 377.4 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцыг бүрдүүлээд байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 259.7%-ийн өсөлттэй байна."                                                                                                                                                                                                                    |         | SDG 13, Mongolia Green Taxonomy          |

## ДАЯН ДЭЛХИЙН ГЭРЭЭНИЙ 10 ЗАРЧИМ

### Зарчим 1

Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх, дэмжих

### Зарчим 6

Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах

### Зарчим 2

Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болохгүй байх

### Зарчим 7

Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх

### Зарчим 3

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх

### Зарчим 8

Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх

### Зарчим 4

Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах

### Зарчим 9

Байгаль орчинд ээлтэй техник, технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх

### Зарчим 5

Хүүхдийн хөдөлмөрийг арилгах

### Зарчим 10

Авлига, хээл хахуулийн бүхий л хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулна.

## ТОДОРХОЙЛОЛТ

### Тогтвортой хөгжлийн 17 зорилго (1/2)



#### Ядуурлыг устгах

Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох.



#### Өлсгөлөнг зогсоох

Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангах тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхүүлэн дэмжих.



#### Эрүүл мэндийг дэмжих

Нийт хүн амыг эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах.



#### Чанартай боловсролыг дэмжих

Хүн бүрт чанартай боловсролыг тэгш хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх.



#### Жендэрийн эрх тэгш байдлыг хангах

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх.



#### Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах

Нийт хүн амыг баталгаат ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангах.



#### Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангах.



#### Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих

Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлт болон бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.



#### Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх

Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг хөхүүлэн дэмжих.



## Тогтвортой хөгжлийн 17 зорилго (2/2)



### Тэгш бус байдлыг бууруулах

Улс орнуудын дотоод дахь болон улс хоорондын тэгш бус байдлыг багасгах.



### Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих

Хот, суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих. өсөлтийг хөхүүлэн дэмжих.



### Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих.



### Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах

Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг яаралтай авах.



### Далай тэнгисийн нөөцийг хамгаалах

Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, нөөцийг тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах.



### Хуурай газрын экосистемийг хамгаалах

Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж, устахаас сэргийлэх.



### Энх тайван, шударга ёсыг цогцлоох

Амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох.



### Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлнэ.



Энэхүү хэлэлцээр нь бүх улс орнуудыг дараах чиглэлд чиглүүлэх урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон.

- Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг эрс бууруулснаар дэлхийн агаарын температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеэс 2 градусаас бага, боломжтой тохиолдолд 1.5 градусаас илүүгүй хэмжээнд барьснаар уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба нөлөөг эрс бууруулах;
- Энэхүү хэлэлцээрийн зорилго болон урт хугацааны зорилтуудад хүрэх хамтын ахиц дэвшлийг тогтмол хэмжих;
- Уур амьсгалын өөрчлөлтийг, тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх, уур амьсгалын нөлөөнд дасан зохицох чадварыг сайжруулах зорилгоор хөгжиж буй орнуудад санхүүжилт олгох.

## НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10 зарчим

## Хүний эрх

## Зарчим 1

Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх, дэмжих

## Зарчим 2

Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болохгүй байх

## Хөдөлмөр эрхлэлт

## Зарчим 3

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх

## Зарчим 4

Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах

## Зарчим 5

Хүүхдийн хөдөлмөрийг арилгах

## Зарчим 6

Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах

## Байгаль орчин

## Зарчим 7

Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх

## Зарчим 8

Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх

## Зарчим 9

Байгаль орчинд ээлтэй техник, технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх

## Авлига, хээл хахуулын эсрэг

## Зарчим 10

Авлига, хээл хахуулийн бүхий л хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулна.

## Монголын тогтвортой санхүүжилтийн 8 зарчим

## Зарчим 1

**Байгаль орчноо хамгаалах**

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй нөөцийг хадгалан хамгаалж, сөрөг нөлөөлөл багатай тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

## Зарчим 2

**Хүний эрх, нийгмийг хамгаалах**

Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

## Зарчим 3

**Соёлын өвийг хамгаалах**

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох хэл соёл, ёс заншил, түүх археологи, палеонтологийн үнэт дурсгалыг хадгалан хамгаалж ажиллана.

## Зарчим 4

**"Ногоон эдийн засаг"-ийн өсөлтийг дэмжих**

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмрээ оруулах төсөл, үйл ажиллагааг дэмжин ажиллана.

## Зарчим 5

**Санхүүгийн хүртээмжийг дэмжих**

Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, харилцагчдадаа санхүүгийн боловсрол олгох, аливаа эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

## Зарчим 6

**Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих**

Бид гэмт хэргийн шинж чанартай ёс суртахуунгүй үйлдэл болон хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзаж, ёс зүйтэй, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

## Зарчим 7

**Ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих**

Бид банкны тогтвортой санхүүжилтийн үүрэг хариуцлагын хүрээнд ил тод, хариуцлагатай байдлыг дэмжин ажиллана.

## Зарчим 8

**Манлайлан үлгэрлэх**

Бид өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа хамтрагч байгууллагууддаа тавьж буй шаардлагыг мөрдөж, Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар ажиллана.

## Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд

## Зарчим 1

Компанийн засаглалд тогтвортой байдлыг тусгах

## Зарчим 2

Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлүүдийг ойлгох

## Зарчим 3

Байгаль орчинтой холбоотой мэдээллээ ил тод тайлагнах

## Зарчим 4

Оролцогч талуудтай харилцааг сайжруулах

## Зарчим 5

Ногоон санхүүгийн хэрэгслийг ашиглах

## Зарчим 6

Ногоон нийлүүлэлтийн сүлжээг нэвтрүүлэх

## Зарчим 7

Хамтын ажиллагаагаар дамжуулан чадавхыг бэхжүүлэх

## Гэр бүлд ээлтэй бодлого

## Зарчим 1

Цаг үргэлж хүүхдийн болон эцэг эхийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих

## Зарчим 2

Хор хохирол учруулахгүй байх

## Зарчим 3

Гэр бүлд ээлтэй бодлогоо ажиллах хүчний хэрэгцээнд тохируулан өөрчлөх

## Зарчим 4

Бүх ажилчдынхаа нийгмийн суурь хамгааллыг дэмжих

## Зарчим 5

Үргэлж давуу хүчтэй эрхзүйн хамгаалалтыг хэрэглэх

## Зарчим 6

Аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхахгүй байх

## Зарчим 7

Мэдээлэл өгөх, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, зөвшөөрөл авах

## Зарчим 8

Тогтвортой байдал болон цар хүрээний хувьд өөрчлөгдөх чадамжтай байдлыг эрхэмлэх

### Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд

#### Зарчим 1

Хүүхдийн эрхийг дээдлэх үүргээ биелүүлж, хүүхдийн эрхийг дэмжихэд хүчин чармайлт гаргах

#### Зарчим 2

Бизнесийн үйл ажиллагаа болон харилцаанд хүүхдийн хөдөлмөрийг устгахад хувь нэмрээ оруулах

#### Зарчим 3

Залуу ажилчид, эцэг эх болон асран хамгаалагчдыг зохистой ажлын байраар хангах

#### Зарчим 4

Бизнесийн бүхий л үйл ажиллагаа болон орчинд хүүхдийн аюулгүй байдал, хамгааллыг хангах

#### Зарчим 5

Бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, түүгээрээ дамжуулан хүүхдэд дэмжлэг үзүүлэх

#### Зарчим 6

Хүүхдийн эрхийг дээдлэн дэмжсэн маркетинг, сурталчилгааг ашиглах

#### Зарчим 7

Хүрээлэн буй орчин, газар эзэмших, ашиглахдаа хүүхдийн эрхийг дээдлэн дэмжих

#### Зарчим 8

Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг дэмжих

#### Зарчим 9

Гамшиг, онцгой байдалд өртсөн хүүхдийг хамгаалахад туслах

#### Зарчим 10

Хүүхдийн эрхийг хамгаалж хэрэгжүүлэх орон нутаг болон Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжих





ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА БОНЗ-ЫН ТАЙЛАН  
**2023**

---



[sustainability@khanbank.com](mailto:sustainability@khanbank.com)



1800-1917



[facebook.com/khanbank](https://facebook.com/khanbank)

[twitter.com/khan\\_bank](https://twitter.com/khan_bank)